



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.04.30 № 311/66
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244001946



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.04.29 № ХЭГ/857
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Засгийн газрын
хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний
дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ᠖᠑ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000245007365



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.04.26 № 01/353

танай 2024.04.25-ны № 02/820 -т

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны
төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн
төсөөллийн тухай хуулийн төслийг Хууль
тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7
дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн
мэдүүлэхийг зөвшөөрөв.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761001746



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

доод 04.29 № 1/2159
танай доод 04.25-ны № 02/830 -т

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР

151601758

Дисциплина 2024

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС



Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:

“10.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх”, 8.1.3-т “Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн зүйлийн 8.1.4-т “Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 06 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9.1.1-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тусгаж тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах” гэж тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр батлах тухай гэсэн нэг зүйлтэй байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл нь Монгол Улсын 2025 оны төсвийн зарлагын хязгаар, 2026-2027 оны дунд хугацааны зарлагын хязгаарын төсөөлөл болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох тооцоо, судалгааны үндсэн суурь үзүүлэлт болж, тэдгээрийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй байна.

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д "эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг ... жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх" гэж, 8.1.3-т "Засгийн газар ... дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэж, 8.1.4-т "Улсын Их Хурал ... дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах" гэж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д "дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тусгаж тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах" гэж тус тус заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах бодлогыг баримталсан бөгөөд Төсвийн тухай хууль 28^{1.4} дэх заалт болон холбогдох журмын дагуу төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангахад олон нийтийн хэлэлцүүлгийг 3 дугаар сард зохион байгуулж, холбогдох хуулийн шаардлагуудад нийцүүлэн боловсрууллаа.

Эдийн засгийн өсөлт 2025 онд эрчимжиж, 8.0 орчим хувьд хүрэх хүлээлттэй байна. Үүнд уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарын экспорт нэмэгдэж, тээвэр логистик, аялал жуулчлал зэрэг үйлчилгээний салбарын үйл ажиллагаа идэвхжихээр байгаа нь голлон нөлөөлөхөөр байна. Цаашид, Оюутолгойн гүний уурхайн эрдсийн өндөр агуулгатай баяжмал үйлдвэрлэл болон бусад уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт нэмэгдэж, худалдааны түнш улс орнуудтай хийж буй худалдааны хэлэлцээрүүдийн хүрээнд хөрөнгө оруулалт, экспорт тогтвортой өссөнөөр 2026, 2027 онуудад эдийн засгийн өсөлт 6.5 хувь орчимд байхаар байна.

Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах, өрхүүдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд инфляцыг бууруулж, 2025 онд 6 хувь, 2026 онд 4 хувь, 2027 онд 3 орчим хувьд хүргэхээр хуулийн төсөлд тусгалаа. Инфляцыг бууруулахад хөдөө аж ахуйн салбарт цогц шинэчлэл хийж хүнсний нийлүүлэлтийг сайжруулах, экспорт, импорттой холбоотой зохицуулалтыг оновчтой хийж, гадаад валютын улсын нөөцийг 10 тэрбум ам.долларт хүргэх, төсвийн алдагдлыг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан төсөвт үзүүлэх нөлөөллийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг ханган боловсрууллаа. Тухайлбал:

- **Тэнцвэржүүлсэн орлого:** Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг олон улсын санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэхээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон.
- **Тэнцвэржүүлсэн тэнцэл:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 оны төсвийн жилээс эхлэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна гэж заасан. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь дотоодын нийт бүтээгдэхүүний 2025 онд -2.0 хувь, 2026 онд -1.5 хувь, 2027 онд -1.0 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангаж байна.
- **Зарлагын өсөлт:** Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь уул уурхайн бус салбарын өсөлт болон өмнөх 12 жилийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байна гэж заасан. Төсвийн нийт зарлага 2025 онд 14.4 хувиар, 2026 онд 7.1 хувиар, 2027 онд 6.3 хувиар өсөхөөр төсөөлсөн нь тусгай шаардлагыг хангаж байна.
- **Засгийн газрын өр:** Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг 2025 онд 50 хувь, 2026 онд 45 хувь, 2027 онд 40 хувь болгон бууруулахаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан 2024 оны төсвийн жилээс эхлэн Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 60 хувиас хэтрүүлэхгүй гэсэн хуулийн шаардлагыг хангаж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар төсвийн хүрээний мэдэгдэл нь Монгол Улсын 2025 оны төсвийн зарлагын хязгаар, 2026-2027 оны дунд хугацааны зарлагын хязгаарын төсөөлөл болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох тооцоо, судалгааны үндсэн суурь үзүүлэлт болж, тэдгээрийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН
2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,
2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР ХОТ
2024 он

АГУУЛГА


1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	3
1.1. Дэлхийн эдийн засгийн төлөв.....	3
1.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага	4
1.3. Монгол Улсын эдийн засгийн 2023 оны урьдчилсан гүйцэтгэл	6
1.4. Эдийн засгийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	13
1.5. Макро эдийн засгийн 2025 оны хандлага, 2026-2027 оны төсөөлөл	14
2. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ 18	
3. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ.....	19
4. ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ТӨСӨӨЛӨЛ	21
4.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны урьдчилсан гүйцэтгэл.....	21
4.1.1. Төсвийн орлого	21
4.1.2. Төсвийн зарлага.....	21
4.2. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл	22
4.2.1. Төсвийн орлого	22
4.2.2. Төсвийн зарлага.....	22
4.3. Нэгдсэн төсвийн үзүүлэлт.....	23
5. МОНГОЛ УЛСЫН 2025-2027 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ, БАРИМТЛАХ СТРАТЕГИ	24
5.3.Төсвийн хөрөнгө оруулалт, бодлого зарчим, хүрэх үр дүн	27
5.3.1. Төсвийн хөрөнгө оруулалт 2019-2024 он	27
5.3.2. Төсвийн хөрөнгө оруулалт 2025-2027 он	27
5.3.3. 2025 онд баримтлах бодлого, шалгуур үзүүлэлт	28
5.4.Гадаад зээл, тусламжийн ашиглалт, баримтлах зарчмууд	28
6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, БАРИМТЛАХ СТРАТЕГИ	29
6.1. Засгийн газрын өр.....	29
6.1.1. Улсын нийт гадаад өр	29
6.1.2. Засгийн газрын өр.....	30
6.1.3. Засгийн газрын гадаад зээл	31
6.1.4. Засгийн газрын гадаад үнэт цаас	32
6.1.5. Засгийн газрын дотоод өр	33
6.2. Засгийн газрын болзошгүй өр төлбөр	35
6.3. Засгийн газрын өрийн тусгай шаардлага	35
6.4. Засгийн газрын 2023-2025 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичиг	36

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1. Дэлхийн эдийн засгийн төлөв

Сүүлийн 4 жилд тохиосон Ковид-19 цар тахал, геополитикийн тогтворгүй байдал, тэдгээрээс үүдэлтэй тээвэр, логистикийн саатал, үнийн өсөлт болон мөнгөний хатуу бодлогын нөлөө 2023 онд үргэлжилсэн хэдий ч ажил эрхлэлт, өрхийн орлого нийт эрэлтийг дэмжсэнээр дэлхийн эдийн засаг 2023 онд 3.2 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлт 2024 болон 2025 онд 3.2 хувьд хадгалагдаж, дунд хугацаанд буюу 2029 онд 3.1 хувь орчимд тогтвортой байна гэж Олон улсын валютын сан тооцоолж байна. Үнийн өсөлтийг хязгаарлахад чиглэсэн мөнгөний хатуу бодлогын хүрээнд хөгжингүй орнууд бодлогын хүүг дунджаар 4 нэгж хувиар, хөгжиж буй орнууд дунджаар 7.8 нэгж хувиар тус тус нэмэгдүүлээд байна. Цаашид нийлүүлэлтийн доголдол болон хөдөлмөрийн зах зээлийн халалт намжиж, дэлхийн инфляцын түвшин 2025 онд 4.5 хувь болж буурч, дийлэнх улсуудын хувьд инфляц зорилтот түвшиндээ хүрсэн байна гэж шинжээчид төсөөлж байна. Улмаар инфляцын бууралт мөнгөний бодлогын төлөвийг сулруулах орон зайг бий болгож, эдийн засгийн идэвхжилийг дэмжихээр байна. Гэсэн хэдий ч геополитикийн тогтворгүй нөхцөл байдал хурцдах, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляц төсөөллөөс удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах, мөнгөний бодлогын төлөв болон өрийн хуримтлалаас шалтгаалан санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүсэх зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг муутгаж болзошгүй байна.

Зураг 1.1. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөвийн тайлангууд, 2024 оны 1-4 дүр сарууд

Хүснэгт 1.1. Улс орнуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	2023	2024	2025
ДЭЛХИЙ	3.2	3.2	3.2
Хөгжингүй орнууд	1.6	1.7	1.8
АНУ	2.5	2.7	1.9
Евро бүс	0.4	0.8	1.5
Япон	1.9	0.9	1.0
Хөгжиж буй орнууд	4.3	4.2	4.2
БНХАУ	5.2	4.6	4.1
ОХУ	3.6	3.2	1.8

Эх сурвалж: "Дэлхийн эдийн засгийн төлөв" тайлан, ОУВС, 2024 оны 4 дүгээр сар

БНХАУ: БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2023 онд 5.2 хувьд хүрч, тус улсын Засгийн газрын зорилтот 5 хувиас давлаа. 2023 онд худалдааны эргэлт буурч, залуучуудын ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, дефляци бий болсон хэдий ч аж үйлдвэрлэлийн салбар өсөж, хэрэглээ нэмэгдсэн нь нийт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжлээ. Тус улс эдийн засгийн өсөлтийг дэмжих хүрээнд төсөв, мөнгөний тэлэх бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ ипотекийн зээлийн урьдчилгаа болон хүүгийн хувь, хэмжээг бууруулах, үл хөдлөх хөрөнгө хөгжүүлэгч компаниудын санхүүжилтийн эх үүсвэрийг дэмжих зэрэг үл хөдлөх салбарт чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. БНХАУ-ын Засгийн газар 2024 онд эдийн засгийн өсөлт 5 хувь, төсвийн алдагдал ДНБ-ий 3 хувь, инфляц 3 орчим хувьд байх зорилтуудыг зарласан бөгөөд 2024 оны эхний улиралд эдийн засгийн өсөлт

5.3 хувьд хүрч эрчимжлээ. Олон улсын валютын сан тус улсын эдийн засгийг 2024 онд 4.6 хувиар, 2025 онд 4.1 хувиар тус тус өснө гэж төсөөлж байна. Ирэх жилүүдэд технологи, уур амьсгалын өөрчлөлт, геополитикийн асуудлуудыг тойрсон дэлхий дахины болон БНХАУ доторх өрнөлүүд тус улсын улс төр, эдийн засгийн төлөвт нөлөөлөхөөр байна.

ОХУ: ОХУ-Украины нөхцөл байдлын улмаас дэлхийн улс орнууд ОХУ-ын эсрэг үе шаттай эдийн засгийн хориг арга хэмжээ авсан ч тус улсын эдийн засаг 2023 онд 3.6 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтөд цэрэг армийн зардалтай холбоотой төсвийн зардал 2021 онтой харьцуулахад 31 хувиар өссөн мөн түүхий эдийн өндөр үнэ гол нөлөө үзүүлээ. Украины дайралттай холбоотой газрын тос шилжүүлэн ачих, тээвэрлэх үйл ажиллагаа түр зогссон, Хар тэнгис дэх далайн шуурганы улмаас ОХУ-ын боомтуудын тээврийн хөдөлгөөн хязгаарлагдмал байгаа зэрэг нь тус улсын экспортод сөргөөр нөлөөлсөн хэвээр байна. Олон улсын валютын сан тус улсын эдийн засгийг 2024 онд 3.2 хувиар, 2025 онд 1.8 хувиар өснө гэж төсөөлж байна.

АНУ: Өрхийн хэрэглээ, экспортын өсөлтийн нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг 2023 онд 2.5 хувиар өслөө. АНУ-ын төв банк бодлогын хүүг 2022 оноос хойш нийт 5.25 нэгж хувиар нэмэгдүүлсэн бөгөөд 2022 оны 6 дугаар сард 9.1 хувь хүртэл нэмэгдсэн инфляц 2024 оны 3 дугаар сард 3.5 хувь болж буураад байна. Цаашид үнийн өсөлт саарч, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлт сайжирснаар бодлогын хүү 2024 оны 4 дүгээр улирал гэхэд одоогийн түвшнээс 0.8 нэгж хувиар буурна гэж Олон улсын валютын сан тооцоолж байна. Тус улсын эдийн засгийн өсөлт 2024 онд 2.7 хувь, 2025 онд 1.9 хувь байна гэж Олон улсын валютын сан тооцоолж байна.

Евро бүс: Эрчим хүчний үнийн шокоос үүдэлтэй инфляц 2023 онд аажмаар саарч оны эцэст 2.9 хувьд болж буурсан ч хэрэглээ хангалттай түвшинд хүрч сэргээгүй, инфляцыг хязгаарлахаар хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр бүс нутаг дах хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа суларч, евро бүсийн эдийн засгийн өсөлт 2023 онд хүлээлтээс доогуур буюу 0.4 хувь байлаа. Эрчим хүчний үнийн шокийн нөлөө аажмаар саарч, инфляцын бууралт өрхийн хэрэглээг дэмжсэнээр тус бүсийн эдийн засгийн өсөлт 2024 онд 0.8 хувь, 2025 онд 1.5 хувьд хүрнэ гэж Олон улсын валютын сан тооцоолж байна.

1.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

Зэсийн үнэ: Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн дундаж үнэ 2023 онд 8,479 ам.доллар болж, өмнөх оноос 4 хувиар буурсан байна. Чили болон Перу дэх уурхайнуудын усны нөөц болон ажил хаялтаас шалтгаалан зэсийн олборлолт удааширч, зэсийн үнэ 2022 онд өссөн бол 2023 он гарснаар зэсийн олборлолт тогтворжиж, Лондоны металлын биржийн агуулах дахь зэсийн хэмжээ нэмэгдсэн нь зэсийн үнэ буурахад голлон нөлөөллөө. Дэлхийн томоохон зэсийн ил уурхайнуудын нэг болох "Кобре Панам" хаагдсан, "Англо Американ" компани зардлаа танаж, зэсийн үйлдвэрлэлээ бууруулахаа мэдэгдсэн нь богино хугацаанд нийлүүлэлтийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна. Сэргээгдэх эрчим хүч, цахилгаан автомашины үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр зэсийн эрэлт дунд хугацаанд нэмэгдэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар

зэсийн дундаж үнэ 2024 онд 8,800 ам.доллар, 2025 онд 9,000 ам.доллар болж өсөхөөр байна.

Алтны үнэ: Алтны дундаж үнэ 2023 онд 1,943 ам.доллар болж, өмнөх оноос 8 хувиар өслөө. Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал болон геополитикийн хурцадмал байдал нэмэгдэж байгаа энэ орчинд алтны эрэлт нэмэгдэж, үнэ өсөж байна. Дэлхийн банкны үзэж байгаагаар дунд хугацаанд дэлхийн эдийн засаг тогтворжиж, алтны эрэлт бага зэрэг сулрах хүлээлттэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2024 онд 1,950 ам.доллар, 2025 онд 1,850 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 1.2. Зэсийн үнэ
(ам.доллар/тонн)



Зураг 1.3. Алтны үнэ
(ам.доллар/трой унц)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Төмрийн хүдрийн үнэ: Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) дундаж үнэ 2023 онд 120 ам.доллар болж, өмнөх оноос 1 хувиар өссөн байна. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар сул хэвээр байгаа хэдий ч дэд бүтцийн бүтээн байгуулалтууд нэмэгдэж, аж үйлдвэрийн гарц 4.6 хувиар өссөн нь ган хайлуулах үйлдвэрийн гол түүхий эд болох төмрийн хүдэр, коксжих нүүрсний эрэлтийг нэмэгдүүлж, үнэ өсөх шалтгаан боллоо. Австрали улс шинэ уурхайн бүтээн байгуулалтын төслүүдийг эрчимжүүлж, Бразил улс нийлүүлэлтээ жил бүр 6 хувиар нэмэгдүүлэхээ зарласан нь төмрийн хүдрийн нийлүүлэлт нэмэгдэх хүлээлтийг бий болгож байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2024 онд 120 ам.доллар, 2025 онд 100 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 1.4. Төмрийн хүдрийн үнэ
(ам.доллар/тонн)



Зураг 1.5. Нүүрсний үнэ
(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Коксжих нүүрсний үнэ: Сингапурын бирж дээрх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнэ 2023 онд дунджаар 296 ам.долларт хүрч, өмнөх оны дунджаас 18 хувиар буурсан байна. Байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан саатаад байсан Австралийн коксжих нүүрсний олборлолт хэвийн болж, нийлүүлэлт тогтворжсон нь үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ коксжих нүүрсний татварыг сэргээсэн нь эрэлтийг бууруулахаар байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дундаж үнэ 2024 онд 250 ам.доллар, 2025 онд 215 ам.долларт хүрэхээр байна.

Брент газрын тосны үнэ: Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2023 онд 79 ам.долларт хүрч, өмнөх оноос 2 хувиар буурлаа. ОПЕК-ийн орнууд өнгөрсөн оны 6 дугаар сард 2024 онд олборлох газрын тосны хэмжээг бууруулахаар шийдвэрлэснээс гадна нефть, газрын тосны олборлолтын 35 орчим хувийг бүрдүүлдэг Ойрх дорнод дахь мөргөлдөөн нь газрын тосны нийлүүлэлтийн тогтворгүй байдлыг бий болгож байна. Түүнчлэн, алт болон газрын тосны томоохон хэрэглэгч Энэтхэг улсын эдийн засгийн идэвхжил газрын тосны эрэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дундаж үнэ 2024 онд 85 ам.доллар, 2025 онд 80 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 1.6. Газрын тосны үнэ
(ам.доллар/баррель)



Эх сурвалж: Блүүмберг терминал

1.3. Монгол Улсын эдийн засгийн 2023 оны урьдчилсан гүйцэтгэл

Урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ оны үнээр 2023 онд 68.9 их наяд төгрөг, зэрэгцүүлэх үнээр 30.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 7.0 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөө үзүүлэв.

Уул уурхайн салбар 2022 онд 15.3 хувиар агшаад байсан бол 2023 онд нүүрс, газрын тосны олборлолт, зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 23.4 хувиар тэллээ. Тухайлбал, нүүрс олборлолт 81.2 сая тоннд хүрч, өмнөх оноос 2.2 дахин, харин цар тахлын өмнөх 2019 оноос 1.6 дахин тус тус нэмэгдээд байна. Оюутолгойн гүний уурхайн үйл ажиллагаа 2023 оны 3 дугаар сард эхэлснээр зэсийн баяжмал үйлдвэрлэл 2023 онд 1,395 мянган тоннд хүрч, өмнөх оноос 17 хувиар өслөө. Түүнчлэн, 2022 оны эхний хагаст хилийн боомтын үйл ажиллагааны хязгаарлалтаас үүдэн зогсоод байсан газрын тосны олборлолт 2023 онд сэргэж, 4.9 сая баррельд хүрч, өмнөх оноос 91 хувиар нэмэгдсэн байна. Харин алт олборлолт 14.9 тоннд, төмрийн хүдрийн олборлолт 7.6 сая тоннд хүрч, өнгөрсөн оноос 23 хувь болон 19 хувиар тус тус буурч, 2019 оны түвшинд хүрээгүй хэвээр байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, тээвэр зохион байгуулалт сайжирсны нөлөөгөөр авто болон төмөр замаар тээсэн ачаа, дамжин өнгөрөх ачаа тээвэр нэмэгдэн тээврийн салбар 39.3 хувиар тэлж, нийт эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг бүрдүүлэв.

Өрхийн орлого сэргэн эдийн засгийг идэвхжүүлсний нөлөөгөөр 2023 онд аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний салбарууд болон цэвэр татварын орлого өслөө. Тухайлбал, бөөний болон жижиглэн худалдааны салбар 2023 онд 5.7 хувиар тэлсэн байна. Үйлчилгээний бусад салбаруудын хувьд удирдлагын дэмжлэг үзүүлэх, зочид буудал, нийтийн хоол, шинжлэх ухааны үйл ажиллагаа, урлаг, үзвэрийн үйлчилгээнүүд өсөлттэй байлаа. Засгийн газар 2023 оны 2 дугаар сард махны экспортын тоо хэмжээний хязгаарлалтыг цуцалснаар мах боловсруулах үйлдвэрлэл, махны экспорт өсөж, боловсруулах салбар өмнөх оноос 5.1 хувиар тэлж, нийт өсөлтийн 0.4 нэгж хувийг бүрдүүлэв.


Ковид-19 цар тахал, геополитикийн тогтворгүй байдлаас шалтгаалан барилгын материалын нийлүүлэлт тасалдсанаар барилгын материалын үнэ өссөн нь барилгын салбарын өсөлт сааруулж, 2023 онд 0.6 хувиар өслөө. 2022 он төмөр зам, автозамын томоохон бүтээн байгуулалт хэрэгжсэн жил байсан бол 2023 онд дээрх суурийн нөлөөгөөр инженерийн барилга байгууламж буурч, барилгын салбарын өсөлтийг хязгаарласан байна.

Харин өвөлжилт хүндэрснээр хөдөө аж ахуйн салбарын 90 гаруй хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн үйлдвэрлэл буурч, нийт эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө. Оны эхнээс төл бойжилт 28 хувиар буурч, малын зүй бус хорогдол өмнөх оноос 6.4 дахин нэмэгдсэнээр мал аж ахуйн салбар 10.3 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 1.4 нэгж хувиар бууруулав. Харин газар тариалангийн салбарын үйлдвэрлэл өмнөх оноос 8 хувиар өсөж, өсөлтөд эергээр нөлөөлсөн байна.

Хүснэгт 1.2. Эдийн засгийн өсөлтийн бүтэц (нэгж хувь)

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
ДНБ	5.6	-4.6	1.6	5.0	7.0
ХАА	0.7	0.8	-0.8	1.7	-1.3
Үйлдвэрлэл	0.9	-1.3	-0.6	-1.2	3.1
Уул уурхай	-0.3	-1.4	0.1	-2.1	2.6
Боловсруулах	0.3	0.3	-0.1	0.5	0.4
Цахилгаан, ус	0.1	0.0	0.2	0.1	0.1
Барилга	0.7	-0.1	-0.9	0.2	0.0
Үйлчилгээ	2.9	-3.0	1.8	3.2	4.3
Худалдаа	1.2	-1.4	0.6	1.1	0.7
Тээвэр	0.2	-1.0	-0.3	0.4	1.8
Бусад	1.5	-0.6	1.5	1.7	1.9
Цэвэр татвар	1.0	-1.1	1.3	1.4	0.9

Зураг 1.7. Эдийн засгийн өсөлт дэх салбаруудын оролцоо (нэгж хувь)



Эрэлт: Гадаад эрэлт тогтвортой байж, нүүрсний экспорт өссөн бол инфляц, ханшийн тогтворжилт, цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт иргэдийн амьжиргаанд ирэх дарамтыг бууруулж, өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэн улмаар эдийн засгийн дотоод идэвхжилийг дэмжлээ. Тухайлбал, нүүрсний экспорт 2023 онд 69.6 сая тоннд хүрснээр бараа, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал бодит дүнгээр өмнөх оноос 16.6 хувиар буурлаа.


Засгийн газраас иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор цалин, тэтгэвэр, тэтгэмж, халамжийг нэмэгдүүлснээр өрхийн бодит орлого 2022 оны эцсээс 14.1 хувиар нэмэгдлээ. Өрхийн орлогын өсөлтийн нөлөөгөөр өрхийн хэрэглээ өмнөх оноос 7.4 хувиар тэлж, дотоод эрэлтийг нэмэгдүүллээ. Үүний зэрэгцээ уул уурхай дагасан бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн өсөлтийн нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал 2023 онд 7.0 хувиар нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.

Инфляц: Жилийн инфляц 2023 оны эцэст улсын хэмжээнд 7.9 хувь гарлаа. Гадаад зах зээлд хүнсний бүтээгдэхүүн болон тээврийн зардлын үнэ буурсан, макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд инфляц төв банкны зорилтот түвшинд орлоо. Засгийн газраас гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр дүнд валютын зах зээл тогтворжиж, төгрөгийн ханш сулрах дарамт буурснаар импортын барааны инфляц буурсан хэдий ч дотоодын бараа бүтээгдэхүүний үнэ өндөр хэвээр байна.

Мөнгөний нийлүүлэлт: Мөнгөний нийлүүлэлт 2023 онд эрчимжиж, оны эцэст 37.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 26.8 хувиар өслөө. Үүнд төлбөрийн тэнцэл сайжирсантай холбоотойгоор арилжааны банкнуудын гадаад цэвэр актив нэмэгдсэн болон дотоод зээл олголт өссөн нь голлон нөлөөллөө. Эх үүсвэр талаас төгрөгийн эх үүсвэр нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлт өсөхөд голлон нөлөөллөө. Тухайлбал, нийт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 23.9 нэгж хувийг төгрөгийн харилцах, хадгаламж, 2.7 нэгж хувийг гадаад валютын харилцах, хадгаламж тус тус бүрдүүлсэн байна. Арилжааны банкнуудын зээл олголт эрчимжсэнээр зээлийн үлдэгдэл 2023 оны эцсийн байдлаар өмнөх оноос 23.4 хувиар өслөө. Зээлийн үлдэгдлийн өсөлтөд иргэдийн цалин, тэтгэврийн зээлийн өсөлт голлон нөлөөллөө.

Зураг 1.8. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үлдэгдэл


1. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт актив тал (хувь)



2. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт пассив тал (хувь)



3. Зээлийн үлдэгдлийн өсөлт (хувь)



Эх сурвалж: Монголбанк

Ажил эрхлэлт, ажилгүйдэл: Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өсөж, 55.4 хувьд, ажилчдын тоо 38.6 мянгаар нэмэгдэж, 1,196 мянгад хүрлээ. Гэсэн ч ажилчдын тооны өсөлтийн хурд

цар тахлын өмнөх үеэс 4 дахин бага байна. Салбараар харвал худалдаа, боловсруулах, тээвэр, үйлчилгээ, уул уурхай, эрчим хүчний салбарт ажилчдын тоо өссөн байна. Харин хөдөө аж ахуйн салбарт сүүлийн 2 жил дараалан зудын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор ажиллагчдын тоо 10 хувиар буурч, 261 мянган хүнд хүрлээ.


Ажилчдын тоог насны бүлгээр харвал, 15-24 насныхны хөдөлмөрийн идэвх сул байна. Тухайлбал, ажилчдын тоо 25-аас дээш насны бүлэгт 4.4 хувиар нэмэгдсэн бол 15-24 насны ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 8 хувиар буурч 88 мянгад хүрсэн байна. Мөн 15-24 насны иргэдийн ажилгүйдлийн түвшин 0.9 нэг хувиар нэмэгдэж 10.4 хувьд хүрсэн нь бусад насны бүлгүүдээс харьцангуй өндөр байна.

Түр зуурын буюу цалин бага учраас, ажиллах сонирхол бага, улирлын чанартай ажил хийдэг шалтгаантай ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо өмнөх оны мөн үеэс 9 мянгаар нэмэгдсэн бол тэтгэвэрт гарсан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг урт хугацаанд ажиллах хүчнээс гадуурх хүн амд харьяалагддаг иргэдийн тоо 19 мянгаар нэмэгдсэнээр нийт ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 28 мянгаар өсөж, 916 мянгад хүрлээ.

Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 28 хувиар өсөж, 2,235 мянган төгрөгт хүрлээ. Салбараар задлан харвал, хөдөө аж ахуй, цахилгааны салбарын ажилчдын дундаж цалин өмнөх оны мөн үеэс 34 хувь болон 32 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1.9. Хөдөлмөрийн үзүүлэлт

1. Ажилчдын тоо, түүний өөрчлөлт (мянган хүн)



2. Ажилчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо
Тэмдэглэл: 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар харуулав.

Гадаад худалдаа: Экспортын барааны урсгал нэмэгдэж, импортын барааны үнийн өсөлт бага байснаар 2023 онд гадаад худалдааны тэнцэл өмнөх оноос 23 хувиар өсөж, 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспорт 15.2 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 17 хувиар, импорт 9.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 6 хувиар тус тус өслөө.

Засгийн газраас 2023 онд экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх түвшинд хүргэх зорилт тавьж ажилласан бөгөөд энэ хүрээнд гадаад валютын улсын нөөц, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд ашигт малтмал тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд онцгой дэглэм тогтоож, компанийн үйл ажиллагаа бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, уул уурхайн бүтээгдэхүүнийг биржийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг

ажлуудыг хэрэгжүүллээ. Мөн хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад чингэлэг тээврийн терминал байгуулж, автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл ашиглалтад нэвтэрсэн зэрэг хүчин зүйлсийн үр дүнд Монгол улс 2023 онд 69.6 сая тонн нүүрс экспортолж, экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ цар тахлын өмнөх түвшинд амжилттай хүрлээ.

Ашигт малтмалыг нээлттэй, ил тод, зах зээлийн өрсөлдөөнт зарчмаар борлуулах хүрээнд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлүүлэн нийт 15 сая тонн нүүрс, 677 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг арилжсан. Биржийн арилжаа эхлэхээс өмнө 1 тонн коксжих нүүрс 100-115 ам.доллар, 1 тонн төмрийн хүдрийн үнэ 60-70 ам доллароор борлуулагдаж байсан бол биржээр арилжаалснаар нүүрсний үнэ дунджаар 10 хувиар, төмрийн хүдрийнх дунджаар 7 хувиар тус тус нэмэгдсэн байна. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалснаар уурхайн ам нөхцөлөөр хямд үнээр худалддаг, тээврийг худалдан авагч тал хариуцдаг зэрэг үр ашиг багатай асуудлууд засагдлаа.

Зураг 1.10. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Оюутолгойн бүлэг ордын нийт нөөцийн 80 гаруй хувийг бүрдүүлдэг, ил уурхайтай харьцуулахад эрдсийн өндөр агуулгатай гүний уурхай 2023 онд ашиглалтад орсонтой холбоотойгоор зэсийн баяжмалын экспорт 2023 онд 1,525 мянган тоннд хүрч, 2016 оноос хойших дээд хэмжээнд хүрлээ. Газрын тосны экспорт 2023 онд 4.7 сая баррельд хүрч, өмнөх оноос 2 дахин өсөхөд цар тахлаас шалтгаалан 2022 оны эхний хагас жилд хаагдаад байсан Дорнод аймаг дахь хилийн боомтуудын үйл ажиллагаа 2023 онд тогтворжсон нь нөлөөллөө. Мөн төмөр замын зохион байгуулалт сайжирсантай холбоотойгоор төмрийн хүдрийн экспорт 5.6 сая тоннд хүрч нэмэгдлээ.

Махны экспортыг нэмэгдүүлэх, хувийн хэвшил бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд Засгийн газраас махны экспортод тавих хязгаарлалтыг цуцалж, "Экспортын гэрчилгээний нэг цонхны цахим систем"-ийг нэвтрүүлснээр 2023 онд махны экспорт 309 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 6 дахин нэмэгдлээ. Мөн боловсруулаагүй арьс, ширний экспортыг хориглох тухай Засгийн газрын 2013 оны 300 дугаар тогтоолын шийдвэрийг 2023 оны 372 дугаар тогтоолоор хүчингүй

болгосноор 2013 оноос хойш 10 дахин буураад байсан арьс, ширний экспорт 2023 онд 3.5 сая ам.долларт хүрч, ОХУ, Турк, Итали, Узбекистан улсууд руу түүхий арьс, шир экспортолж эхэллээ.

Худалдааны түнш орнуудын инфляц эрчимжсэнтэй холбоотойгоор 2022 онд импорт 1.9 тэрбум ам.доллараар өссөний 54 хувийг үнийн өсөлт бүрдүүлж байсан бол 2023 онд импорт 0.5 тэрбум ам.доллараар өссөний 5 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлж, импортын барааны үнийн өсөлтийн дарамт бага байлаа. Үүнд БНХАУ-ын инфляцын бууралт, ОХУ-Украин хоорондын геополитикийн тогтворгүй байдлаас үүдэн эрчимтэй өсөөд байсан нефтийн бүтээгдэхүүн, бордоо, үр тарианы үнэ 2023 онд тогтворжиж, буурсан нь голлох нөлөөг үзүүллээ. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2022 онд хилийн боомтуудын үйл ажиллагаа түр саатаж, БНХАУ-ын Тяньжин боомтод чингэлгийн бөөгнөрөл үүсэж, импортын барааны урсгал 3 сар хүртэлх хугацаагаар саатаж байсан бол 2023 онд хилийн боомтуудын үйл ажиллагаа хэвийн үргэлжиллээ.

Уул уурхай, тээвэр, боловсруулах үйлдвэрийн салбарын өсөлтийг дагаж тоног төхөөрөмж, машин механизм, дизелийн түлшний импорт өндөр байсан нь импортын өсөлтөд голлох нөлөөг үзүүллээ. Тухайлбал, нүүрсний тээвэрлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор дизелийн түлшний импорт 2023 онд 1,090 мянган тоннд хүрч, өмнөх оноос 39.0 хувиар өссөн бол хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас чөлөөлснөөр тус барааны импорт 2023 онд 255 сая ам.доллар болж, өмнөх оноос 55.8 хувиар өслөө. Тоног төхөөрөмжийн өсөлт цаашид дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихээр байна.

Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, өрхийн бодит орлого болон зарлага өссөнөөр 2023 онд хүнсний бус хэрэглээний бүтээгдэхүүн, тэр дундаа суудлын автомашины импорт өндөр байв. Харин согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж, согтууруулах ундааны онцгой албан татвар нэмэгдсэнээр тус бүтээгдэхүүний импорт буурсан.

Зураг 1.11. Гадаад худалдааны үзүүлэлт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тэмдэглэл: Импортын бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний зориулалтаар ангилав.

Төлбөрийн тэнцэл: Засгийн газраас гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн цогц арга хэмжээнүүдийн үр дүнд экспорт нэмэгдэж, төлбөрийн тэнцэл 2023 оны эцэст 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын улсын нөөц 2023 оны эцэст 4,921 сая ам.долларт хүрч нэмэгдэж, төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2023 оны эцэст 3411 төгрөг болж, оны эхнээс 37 төгрөгөөр буюу 1.1 хувиар чангарсан байна. Экспорт өссөнтэй холбоотойгоор 2023 онд урсгал данс 2007 оноос хойш анх удаа ашигтай гарсан бол шууд хөрөнгө оруулалтын орох урсгал буурч, гадаад бондуудын эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотойгоор санхүүгийн дансны ашиг өмнөх оноос буурлаа. Монгол Улсын Засгийн газар 2023 онд Сенчири-2 болон Сенчири-3 төслүүдийн хүрээнд нийт 1 тэрбум ам.долларын бондыг олон улсын зах зээлд амжилттай арилжааллаа. Цар тахал, геополитикийн тогтворгүй байдалтай нүүр тулсан сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газар өрийн зохицуулалтын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснээр төсөв, төлбөрийн тэнцэлд ирэх дарамтыг бууруулж, өрийн дефолтын эрсдэлээс сэргийлж, зээлжих зэрэглэлийг тогтвортой хадгалж чадлаа.

Зураг 1.12. Төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц, гадаад өр



Эх сурвалж: Монголбанк

1.4. Эдийн засгийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Үндэсний статистикийн хорооны урьдчилсан тооцоогоор эдийн засгийн өсөлт 2024 оны эхний 2 сарын байдлаар 7.8 хувь байна. Эдийн засгийн өсөлт жилийн эцэст 6.0 орчим хувь байхаар төсөөлж байна. Оюутолгойн гүний уурхайн олборлолт үргэлжилснээр баяжмал дахь зэс болон алтны агууламж нэмэгдэнэ. Мөн нүүрс, алт, төмрийн хүдрийн олборлолт өссөнөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэхээр байна. Уул уурхайн салбарын дам нөлөөгөөр ачаа тээвэр өсөлттэй байх бол жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүд хэрэгжүүлснээр 2024 оны сүүлийн хагас жилд аялал жуулчлал, үйлчилгээний салбар өсөх хүлээлттэй байна. “Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай” хууль батлагдаж, хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах тоног төхөөрөмжийн импортын татварыг тэглэснээр 2023 онд тоног төхөөрөмжийн импорт нэмэгдсэн бөгөөд уг нөлөөгөөр уул уурхайн бус, боловсруулах салбаруудын гарц нэмэгдэхээр байна. Харин цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас том малын зүй бус хорогдол 2023 оны түвшнээс давж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2024 онд агшихаар байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмж 2024 оны 2 дугаар улиралд нэмэгдсэнээр өрхийн хэрэглээ өсөж, дотоод эрэлт сайжран, улмаар худалдаа, үйлчилгээний борлуулалт нэмэгдэн эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Гадаад худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны эхний 3 сарын байдлаар 6.1 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 6.5 хувиар өслөө. 2024 оны жилийн эцэст нийт бараа эргэлт 28.6 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 6.1 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах, тээвэр зохион байгуулалтыг оновчтой хийх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг өргөтгөх зэрэг арга хэмжээнүүдийн үр дүнд нүүрсний экспорт 78 сая тоннд хүрч, нийт экспортын дүн 2024 оны эцэст 17.4 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Харин өрхийн орлого, зээл олголт нэмэгдэж, эдийн засгийн өсөлт тогтвортой байснаар импорт 2024 оны эцэст 11.3 тэрбум ам.долларт хүрч өсөхөөр байна.

Инфляц: Инфляц 2024 оны 3 дугаар сард 7.0 хувьд хүрч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдаж байна. Гадаад валютын зах зээл тогтвортой байснаар импортын гаралтай инфляцын дарамт бага байх хүлээлттэй байна. Харин өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамт хадгалагдах эрсдэл хэвээр байна.

Төлбөрийн тэнцэл: Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 2 сарын байдлаар 39 сая ам.долларын ашигтай гарч, ашиг өмнөх оны мөн үеэс 28 сая ам.доллараар буураад байна. Экспортын орлого нэмэгдэж, хуваарьт гадаад өр төлбөрийн дарамт буурснаар 2024 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын нөөц нэмэгдэх хүлээлттэй байна. Монгол Улсын Засгийн газар 2017 онд гаргасан 600 сая ам.долларын Хуралдай бондын өрийг 2024 оны 3 дугаар сард бүрэн төлж барагдуулсан нь төлбөрийн тэнцлийн дарамтыг буурууллаа.

1.5. Макро эдийн засгийн 2025 оны хандлага, 2026-2027 оны төсөөлөл

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Засгийн газраас дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг тогтвортой түвшинд хадгалахаар зорьж байна. Эдийн засгийн өсөлт 2025 онд эрчимжиж, 8.0 орчим хувьд хүрэх төлөвтэй байна. Үүнд уул уурхай, хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбаруудын өсөлт голлон нөлөөлнө гэж үзэж байна. Тухайлбал, Оюутолгойн гүний уурхайгаас олборлох зэсийн баяжмалын үйлдвэрлэл болон баяжмал дахь зэс, алтны агуулга нэмэгдсэнээр уул уурхайн салбар 2025 оны эдийн засгийн өсөлтийн гуравны нэгийг бүрдүүлэхээр байна. Хөдөө аж ахуйн салбарт бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлж, өвөлжилт, хаваржилт хэвийн үргэлжлэх нөхцөлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 2025 онд мөн өсөхөөр байна. Түүнчлэн, дотоодын худалдаа, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж, эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөх төлөвтэй.

Эдийн засгийн өсөлт 2026-2027 онд 6.5 хувь орчимд байхаар төсөөлж байна. Оюутолгойн гүний уурхайн эрдсийн өндөр агуулгатай баяжмал үйлдвэрлэл болон бусад уул уурхайн түүхий эдийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. Дунд хугацаанд хөгжлийн бодлогын баримт бичигт туссан төсөл, арга хэмжээ болон салбаруудын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалахаар зорьж байна. Тухайлбал, эрчим хүчний салбарт либералчлалыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн боломжит хүчин чадлыг нэмэгдүүлж, эдийн засгийн багтаамжийг тэлнэ. Бүх салбарт үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн татвар, тарифыг хөнгөлөх бодлого хэрэгжүүлж, хөдөө аж ахуй, боловсруулах, уул уурхай гэх мэт салбаруудын үйлдвэрлэлийн ахиу зардлыг бууруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх эерэг нөлөө үзүүлнэ. Мөн хөрш орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр хийх ажлыг эрчимжүүлснээр аж үйлдвэр, боловсруулах салбарыг дэмжинэ. Түүнчлэн, гадаадын жуулчдын тоо, аялал жуулчлалын орлогыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд худалдаа, үйлчилгээний салбар болон бусад салбаруудын идэвхжилд эергээр нөлөөлнө.

Зураг 1.13. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл


1. Дотоодын нийт бүтээгдэхүүн (их наяд төгрөг, хувь)

2. Гадаад худалдаа (тэрбум ам.доллар)



• Тасвирлар

Эх сурвалж: Тооцоолол, ҮСХ-ны статистик



* Төсвөдөл

Эх сурвалж: Тооцоолол, ГЕГ-ын статистик

Гадаад худалдаа: Гадаад худалдаа эрчимжиж, 2025 онд экспорт 19.2 тэрбум ам.доллар, импорт 12.5 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 6.7

тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Монгол Улсын Засгийн газраас гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийг өргөжүүлэх, хилийн боомтуудын дэд бүтцийг нэмэгдүүлж, ачаа нэвтрүүлэх процессыг хөнгөвчлөх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр экспорт жилд дунджаар 10 хувиар өсөж, 2027 онд 23 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Харин эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр үйлдвэрлэлийн завсрын хэрэглээний бүтээгдэхүүний импорт нэмэгдсэнээр нийт импорт жилд дунджаар 10 орчим хувиар нэмэгдэхээр байна. Мөн бараа, бүтээгдэхүүнийг импортлохтой холбоотой бүртгэлийг автоматжуулж, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг өргөжүүлж, нэг боомт дээр төвлөрсөн ачааллыг бууруулснаар импортын барааны эргэлтийн хурд нэмэгдэхээр хүлээгдэж байна. Монгол Улсын гадаад худалдаа 2026-2027 онд дунджаар 7 орчим тэрбум ам.долларын ашигтай байх төлөвтэй байна.

Инфляц: Дунд хугацаанд хөдөө аж ахуйн салбарт цогц шинэчлэл хийж хүнсний нийлүүлэлтийн сүлжээг нэмэгдүүлэн, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш тогтвортой хадгалагдан, төсвийн алдагдлыг хязгаарлах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд инфляц 2025-2027 онд буурч, 3 хувийн орчимд хүрэхээр төсөөлж байна.

Төлбөрийн тэнцэл: Засгийн газрын төлөх үүрэг бүхий гадаад үнэт цаасны хуваарьт төлбөр 2026 он хүртэл байхгүй нь төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулж байна. Экспортын орлого тогтвортой нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэл дунд хугацаанд буюу 2025-2027 онд ашигтай гарч, гадаад валютын нөөц тогтвортой нэмэгдэн 10 тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна.

Макро эдийн засгийн төсөөлөлд учирч болзошгүй эрсдэл

Нэг. Геополитикийн зөрчил гүнзгийрэх, хамрах хүрээ тэлэх: ОХУ-Украины нөхцөл байдал даамжрах, дэлхийн нефть, газрын тосны экспортын 35 орчим хувийг бүрдүүлдэг Газын зурвас, Израйл орчмын бүс нутгийн мөргөлдөөн хурцдах, дэлхийн худалдааны 11 орчим хувь дамжин өнгөрдөг Улаан тэнгист халдлага үргэлжлэх болон геополитикийн зөрчлийн хамрах хүрээ тэлэх зэрэг эрсдэлүүд авто бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг манай улсын импортын голлох бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж болзошгүй байна.

Хоёр. Түүхий эдийн үнийн хэлбэлзэл: Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлаас шалтгаалсан эрэлт, нийлүүлэлтийн тогтворгүй байдал манай улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн гадаад зах зээл дээрх үнийн хэлбэлзлийг нэмэгдүүлж, манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Тухайлбал, түүхий эдийн дэлхийн зах зээлд өндөр нөлөө бүхий БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж, тус улсын эдийн засгийн өсөлт хүлээлтээс доогуур байх нь манай улсын экспортын түүхий эдийн эрэлт, үнийг бууруулах замаар экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй

Гурав. Зуд, ган, мал, амьтны өвчин: Цаг агаарын таагүй нөхцөл байдлаас өндөр хамааралтай хөдөө аж ахуйн салбарт зудын эрсдэл нэмэгдэж, хаваржилт хүндрэх, зуншлага тааруу байх, ган тохиолдох, малын халдварт өвчин тархах эрсдэл өндөр байна. Улмаар хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, өрхүүдийн орлого буурах, орлогын тэгш бус байдал нэмэгдэх, инфляц нэмэгдэх эрсдэлтэй байна. Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор 2023

онд том малын зүй бүс хорогдол 2010 оноос хойш хамгийн өндөр түвшинд хүрч нэмэгдсэн. Мөн 2024 оны эхнээс ихэнх нутгаар цас их хэмжээгээр орж, жил дараалсан зуд тохиолдож, 3 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд 4.7 сая толгой мал хорогдоод байгаа бөгөөд цаашид нэмэгдэх эрсдэлтэй байна. Малын зүй бүс хорогдол өндөр байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантайгаар махны үнэ нэмэгдэх, хүнсний инфляц өсөх дарамтыг нэмэгдүүлж байна.

Дөрөв. Эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдал: Эрчим хүч нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хүчин зүйл боловч манай улс дотоодын цахилгаан хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй, 20 орчим хувийг хөрш орнуудаас худалдан авч хэрэглэж байна. 2023 оны 12 дугаар сард ОХУ-ын 2 станцад гэмтэл гарснаар Монгол Улс руу нийлүүлэх эрчим хүчийг хязгаарлах тухай мэдэгдсэн ба энэ нь манай улсад эрчим хүчний тасалдал үүсэх эрсдэл өндөр байгааг харуулж байна. Мөн манай улсын эрчим хүчний хангамж нь төвлөрсөн системтэй ба станцуудын насжилт өндөр, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Эрчим хүчний тасалдал нь бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй.

Тав. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг: Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед манай улс аливаа төрлийн хоригт өртөхгүй байх, зээлжих зэрэглэлийг сайжруулах хүрээнд олон улсад баримталж буй дүрэм журмуудыг мөрдөж, зээлжих зэрэглэл тогтоодог болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх нь зүйтэй байна. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

Зургаа. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан байгалийн гамшигт үзэгдлүүд: Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан хүнсний үнийн өсөлт манай улсын инфляцыг өсгөж болзошгүй байна. Дэлхийн цаг уурын байгууллага болон уур амьсгалын судалгаа хийж буй бусад байгууллагууд олон жилийн ажиглалт, судалгаанд үндэслэн дэлхийн уур амьсгал дулаарч байна гэж дүгнэжээ (ТТБЗ, 2024). Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас дэлхийн олон бүс нутагт хэт халалт, хэт хүйтрэлт, хүчтэй хар шуурга, аадар бороо, үер, хөрсний гулгалт зэрэг байгаль цаг уурын гамшигт болон аюулт үзэгдлийн тоо нэмэгдэж байна. Уур амьсгалын өөрчлөлт Ази тивд загас агнуур, газар тариалангийн гарц, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг бууруулах, хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бөгөөд хэрвээ дундаж температур 1-ээс 4 цельсээр нэмэгдсэн тохиолдолд дэлхийн будааны гол экспортлогч Энэтхэг улсын будааны үйлдвэрлэл 10-аас 30 хувиар буурах, эрдэнэ шишийн гарц 25-аас 70 хувиар буурах эрсдэлтэй гэж үзжээ (IPCC, 2022¹). Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан байгалийн гамшигт үзэгдлүүдийн нөлөөгөөр олон улсад тээвэр логистикийн саатал үүсэх, хүнсний болон бусад бүтээгдэхүүний

¹ The Intergovernmental Panel on Climate Change, Sixth Assessment Report, Climate Change 2022: Impacts, Adaptation and Vulnerability

нийлүүлэлт буурах, үнэ өсөх, улмаар манай улсын импортын инфляцын дарамт нэмэгдэх эрсдэлтэй байна.

2. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Хүснэгт 2.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн үзүүлэлт (тэрбум төгрөг)

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
	2025	2026	2027
1 Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ	8.0	6.5	6.5
2 Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.0	4.0	3.0
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ	29,400.1	31,951.2	34,460.3
ДНБ-д эзлэх хувь	30.9	30.5	29.5
4 Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ	31,300.4	33,521.8	35,628.1
ДНБ-д эзлэх хувь	32.9	32.0	30.5
5 Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ	3,939.9	2,221.4	2,106.3
ДНБ-д эзлэх хувь	4.1	2.1	1.8
6 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл/ тэрбум	-1,900.3	-1,570.6	-1,167.8
ДНБ-д эзлэх хувь	-2.0	-1.5	-1.0
7 Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ	7,273.3	7,564.2	7,866.8
ДНБ-д эзлэх хувь	7.7	7.2	6.7
8 Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр	47,507.1	47,117.6	46,708.6
ДНБ-д эзлэх хувь	50.0	45.0	40.0
9 Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ	2,850.4	2,931.8	3,269.6
ДНБ-д эзлэх хувь	3.0	2.8	2.8

3. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна.

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэхээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцлоо. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2025 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 7,491 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 129 ам.доллар байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна гэж заасан. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь дотоодын нийт бүтээгдэхүүний 2025 онд -2.0 хувь, 2026 онд -1.5 хувь, 2027 онд -1.0 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3.1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)

	2025	2026	2027
Хуулийн хязгаар	-2.0	-2.0	-2.0
Төсөөлөл	-2.0	-1.5	-1.0

Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтад тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байна гэж заасан. Нэгдсэн төсвийн нийт зарлага 2025 онд 14.4 хувиар, 2026 онд 7.1 хувиар, 2027 онд 6.3 хувиар өсөхөөр төсөөлсөн нь заасан төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3.2. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн төсөөлөл (хувь)

Өсөлт	2025	2026	2027
Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь	14.4%	7.1%	6.3%
Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	14.4%	14.3%	15.4%
Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	12.6%	12.4%	12.4%

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас хэтрүүлэхгүй байна" гэж заасан. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 2025-аас 2027 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 3.3. Засгийн газрын өрийн төсөөлөл, өнөөгийн үнэ цэнээр (ДНБ-д эзлэх хувь)

	2025	2026	2027
Хуулийн хязгаар	60.0	60.0	60.0
Төсөөлөл	50.0	45.0	40.0

4. ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ТӨСӨӨЛӨЛ

4.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны урьдчилсан гүйцэтгэл

4.1.1. Төсвийн орлого

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 24,310.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 5.6 хувиар буюу 1,284.9 тэрбум төгрөгөөр давсан байна.

Хүснэгт 4.1. Төсвийн орлого (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2021	2022	2023 у.гүйцэтгэл
Тэнцвэржүүлсэн орлого	12,711.4	17,126.9	23,218.0
Татварын орлого	11,300.0	15,459.0	21,450.8
Татварын бус орлого	1,411.5	1,667.9	1,767.2

4.1.2. Төсвийн зарлага

Монгол улсын нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 22,454.5 тэрбум төгрөгийн буюу төлөвлөгдсөн хэмжээнээс 92.7 хувийн, улсын төсвийн зарлага 16,035.2 тэрбум төгрөгийн буюу төлөвлөгдсөн хэмжээнээс 94.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт 4.2. 2023 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагын урьдчилсан гүйцэтгэл, томсгосон ангиллаар (тэрбум төгрөг)

Төсвийн төрөл	Нийт зарлага ба цэвэр зээл	Урсгал зардал				Хөрөнгийн зардал	Эргэж төлөгдөх цэвэр зээл
		Цалин хөлс	БҮ-ний бусад	Зээлийн хүү	Татаас, шилж.		
Нэгдсэн төсөв	22,454.5	2,321.7	2,740.3	1,131.7	10,852.8	5,174.9	233.0
Улсын төсөв	16,035.2	1,870.0	1,722.7	1,080.0	7,254.5	3,937.6	170.3
ОН-ийн төсөв	4,329.7	413.3	1,165.2	51.7	1,393.5	1,237.3	68.6
НДС	4,031.5	32.3	9.9	0.0	3,990.6	0.0	-1.1
ЭМДС	1,598.0	6.2	43.8	0.0	1,552.8	0.0	-4.8
Ирээдүй өв сан	1,488.1	0.0	0.0	0.0	1,488.1	0.0	0.0

4.2. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл

4.2.1. Төсвийн орлого

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 7,673.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 145.1 тэрбум төгрөгөөр бага төвлөрсөн байна.

Хүснэгт 4.3. Нэгдсэн төсвийн орлогын 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2024.3 сар төлөвлөсөн	2024.3 сар гүйцэтгэл	2024 хүлээгдэж буй гүйцэтгэл
Нийт орлого	7,818.4	7,673.3	27,722.2
Тогтворжуулалтын сан	101.0	67.4	513.7
Тэнцвэржүүлсэн орлого	7,462.6	7,321.9	25,855.1

Төсвийн нийт орлого 2024 онд 27.7 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого 25.9 их наяд төгрөг байхаар хүлээгдэж байна. Энэ онд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг дэмжих, хилийн боомтын дэд бүтцийг хөгжүүлэх, экспортыг эрчимжүүлэх, татварын бүртгэл, хамрагдалтыг сайжруулах чиглэлд арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнд 2024 оны эхний улирлын байдлаар эрдэс бүтээгдэхүүний экспорт өсөж, нүүрсний экспорт 17.8 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 28 хувиар өссөн байна.

4.2.2. Төсвийн зарлага

Төсвийн нийт урсгал зардал 2024 онд 21,087.2 тэрбум төгрөг ба үүний 35.9 хувь нь төрөөс иргэдэд олгодог нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмж, 25.3 хувь нь төрийн албан хаагчдад олгох цалин хөлс, 11.7 хувь нь төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой урсгал зардал, 7.3 хувь нь хүүхдийн мөнгөн тэтгэмж, хувь нь төрөөс иргэн, аж ахуйн нэгжид олгох хөнгөлөлт, чөлөөлөлт, 8.5 хувь нь татаас, гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, 1.6 хувь нь гүйцэтгэлээр санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын урсгал зардал тус тус эзэлж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 2024 оны эхний улирлын байдлаар 5,695.3 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 69.3 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Хүснэгт 4.4. Нэгдсэн төсвийн зарлагын 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2024 онд батлагдсан	2024.3 сар төлөвлөсөн	2024.3 сар гүйцэтгэл
Нийт зарлага	27,360.5	8,224.1	5,695.3
Урсгал зардал	21,087.2	6,098.8	4,698.0
Хөрөнгийн зардал	6,273.3	1,905.4	842.9
Эргэж төлөгдөх цэвэр зээл		219.9	154.4

4.3. Нэгдсэн төсвийн үзүүлэлт

Хүснэгт 4.5. Төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2022	2023	2024	2025
	Гүйцэтгэл	Урьд. Гүйц	Батлагдсан	ТХМ
Тэнцвэржүүлсэн нийт орлого	17,126.9	23,217.9	25,875.4	29,400.1
Төсвийн нийт зарлага	18,159.7	22,454.5	27,380.8	31,300.4
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-1,032.7	763.4	-1,505.4	-1,900.3
ДНБ-д эзлэх хувь	-2.0	1.1	-2.0	-2.0

5. МОНГОЛ УЛСЫН 2025-2027 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ, БАРИМТЛАХ СТРАТЕГИ

5.1. Төсвийн 2025-2027 онд баримтлах стратеги

Нэгдсэн төсвийн нийт орлого 2023 онд төлөвлөгөөнөөс 6 хувь давж, сүүлийн таван жилд анх удаа төсвийн тэнцэл ашигтай гарлаа. Түүнчлэн эдийн засаг өмнөх оноос 7.0 хувиар өсөж, нийлүүлэлтийн шалтгаантай инфляц тогтворжиж, экспортын хэмжээ тэлсэн. Тус өсөлтөд төсвийн сахилга батыг төрийн бүх шатанд хэрэгжүүлэх, уул уурхайн далд эдийн засгийг ил болгох, төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа эдийн засгийн салбаруудын жигд өсөлтийг дэмжиж, инфляцын түвшнийг тогтвортой бууруулах бодлого баримтлалаа. Түүнчлэн хуулийн төслийг боловсруулахдаа төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангах, холбогдох хуулийн шаардлагуудад нийцүүлэх, хэрэгжихүйц, бодитой байх зэрэг төлөвлөлтийн үндсэн шалгуурыг баримталсан болно.

- ***Макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ.***

Макро тогтвортой орчныг дэмжсэн төсөв, мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, улсын зээлжих зэрэглэлийг нэг шатаар ахиулна. Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг 2025 онд 2.0 хувь, 2026 онд 1.5 хувь, 2027 онд 1.0 хувь болгон бууруулж, цаашид төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулах, Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангана.

- ***Боловсруулалтын түвшнийг нэг шат ахиулах бодлогыг хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.***

Эдийн засгийг төрөлжүүлэх, бүтээгдэхүүнүүдийн боловсруулалтын түвшнийг шат ахиулах хүрээнд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, уул уурхайн болон уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийг дэмжинэ.

- ***Эдийн засгийг төрөлжүүлэн, экспортыг нэмэгдүүлнэ.***

Эдийн засгийн суурийг тэлэх, төрөлжүүлэх хүрээнд уул уурхайн болон уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ. Уул уурхайн экспортыг нэмэгдүүлэхэд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог бэхжүүлж, өргөжүүлнэ. Зэс, хайлуур жонш, мөнгө зэрэг уул уурхайн бүх бүтээгдэхүүнийг үе шаттайгаар биржээр арилжиж, арилжсан бүтээгдэхүүнийг хилийн боомтын тусгай гарцаар нэвтрүүлнэ.

- ***Зохицуулалтыг хялбарчилж, хувийн хэвшлийг дэмжинэ.***

Аливаа төрлийн бизнес эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлд төрийн зохицуулалтыг хялбарчилж, хувийн секторын чөлөөт өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Эдийн засгийн салбаруудын өрсөлдөөнийг дэмжих, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах чиглэлд хөдөө аж ахуйн салбарт бодлогын цогц шинэчлэл хийнэ.

- ***Татварын бүртгэлийг сайжруулан, далд эдийн засгийг бууруулж, татварын суурийг тэлнэ.***

Бизнес эрхлэгчдийн татвар тайлагнах, төлөх үйл ажиллагааг хялбаршуулан, татварын хамрагдалт, бүртгэлийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- ***Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилан, төвлөрлийг сааруулж, хот хөдөөгийн тэнцвэрийг нэмэгдүүлэх бодлого баримтална.***

Орон нутгийн санхүүжилтийг эдийн засгийн чадавх, үр дүнд суурилсан тогтолцоонд шилжүүлж, урамшууллын механизмыг нэвтрүүлэх замаар Бүсчилсэн хөгжлийг дэмжинэ.

- ***Төсвийн хэмнэлттэй, үр ашигтай зарцуулалтыг сайжруулж, иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.***

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг шинээр бий болгох байнгын ажлын байрны тоо, нийгэм, эдийн засаг, байгаль орчны үр өгөөжөөр нь эрэмбэлж, санхүүжүүлэх зарчмыг баримтална. Төсвийн зарцуулалтад иргэд болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг сайжруулна.

- ***Нийгмийн халамжийн бодлогыг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглүүлж, цалин, тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.***

Төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ. Төрийн албан хаагчдын цалинг ажлын хариуцлага, үр дүн, гүйцэтгэлтэй нь болон инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.

5.2. Монгол Улсын 2025-2027 оны төсвийн орлого, зарлагын төсөөлөл

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан төсөвт үзүүлэх нөлөөллийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу 1) Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх, 2) Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, 3) Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь, 4) Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн тусгай шаардлагыг тус тус хангаж байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 29,400.1 тэрбум төгрөг, Ирээдүйн өв сангийн орлого 3,482.5 тэрбум төгрөг, Тогтворжуулалтын сангийн орлого 538.3 тэрбум төгрөг байхаар тооцоолов.

Хүснэгт 5.1. Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2025 төсөөлөл	2026 төсөөлөл	2027 төсөөлөл
Тэнцвэржүүлсэн орлого	29,400.1	31,951.2	34,460.3

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2025 онд 31,300.4 тэрбум төгрөг болж, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 3,939.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр тооцооллоо.

Хүснэгт 5.2. Төсвийн нийт зарлагын дээд хэмжээ (тэрбум төгрөг)


Үзүүлэлт	2025 төсөөлөл	2026 төсөөлөл	2027 төсөөлөл
Нийт зарлагын дээд хэмжээ	31,300.4	33,521.8	35,628.0

5.3.Төсвийн хөрөнгө оруулалт, бодлого зарчим, хүрэх үр дүн

5.3.1. Төсвийн хөрөнгө оруулалт 2019-2024 он

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2023 онд 9.7 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдаж, 2019-2023 онд 9.0 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдсэн бол 2024 онд хамгийн өндөр төсвийн хөрөнгө оруулалт буюу 3.4 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 1,300 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

Зураг 5.1. УТХО-ын төлөвлөгөө, гүйцэтгэл (их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт 5.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөө

АНГИЛАЛ	Төслийн тоо	Үүнээс: 2024 онд дуусах	Төсөвт өртөг (тэрбум төг)	Санхүүжих дүн (тэрбум төг)
Улсын төсөв	1,299	719	10,552.12	3,359.35
Концесс эргэн төлөлт	1	-	287.40	25.00
Нийт	1,300	719	10,839.52	3,384.35

5.3.2. 2025 онд баримтлах бодлого, шалгуур үзүүлэлт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөх нь эдийн засаг, нийгмийн урт хугацааны хөгжил, өсөлтийг дэмжихэд болон ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулж, амьдрах таатай орчныг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй байдаг тул урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогуудын хүрээнд нийгмийн ач холбогдолтой, эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээнүүдийг төсвийн хөрөнгө оруулалтад тусгахаар төлөвлөж, үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны бодлогод хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих, дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, он дамнасан дуусаагүй барилга

байгууламжийг ашиглалтад оруулах зарчмыг баримтлан, иргэдийн оролцоонд суурилсан ил тод, хэмнэлттэй үр дүнтэй байх зарчмыг баримталсан.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын хувьд дараах бодлого, шалгуур үзүүлэлтийг баримтална. Үүнд:

- 2025 онд шилжих төслүүдийн үлдэгдэл санхүүжилтийг бүрэн тусгана.
- Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд болон Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг төлөвлөнө.
- Иргэдийн оролцоонд суурилсан ил тод, цахим, хэмнэлттэй бөгөөд үр дүнтэй төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлнэ.

5.4.Гадаад зээл, тусламжийн ашиглалт, баримтлах зарчмууд

Монгол Улсын дунд хугацааны гадаад зээл, тусламжийн ашиглалтын төсөөллийг Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого чиглэлтэй уялдуулан дараах зарчмыг үндэслэн төлөвлөлөө. Үүнд:

Нэг. Гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр шинээр эхлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Шинэ сэргэлтийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулна. Энэ хүрээнд арилжааны нөхцөлтэй гадаад зээллэгийн эх үүсвэрээр эргэн төлөгдөх чадвартай төсөл арга хэмжээг санхүүжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжтой төсөл арга хэмжээг гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхгүй байх зэрэг Өрийн удирдлагын тухай хуульд заасан зарчмуудыг чанд баримтлан ажиллана.

Түүнчлэн төслүүдийг нэн тэргүүний ач холбогдол, бэлэн байдлаар нь эрэмбэлж, зайлшгүй шаардлагатай, бодит үр дүн гарах, нийгэм, эдийн засгийн ач холбогдол өндөртэй цөөн тооны томоохон төслүүдийг гадаад зээл, томоохон тусламжаар санхүүжүүлнэ. Тухайлбал нийслэл Улаанбаатар хотод дагуул хот хөгжүүлэх, Эмээлт аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц, хотын зам, гарц, нийтийн тээвэр, үер ус, далан сувгийн өргөтгөл, шугам сүлжээний шинэчлэлийн төслүүд, хөдөө орон нутагт бүс орон нутгийн авто зам барих зэрэг дэд бүтэц, хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлнэ.

Эрчим хүчний салбарын үнэ тарифыг либералчлах, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлж, салбарын төсөл, арга хэмжээг гадаадын зээлээр биш бие даан санхүүжүүлэх хэмжээнд хүргэх бодлого баримталж байна. Мөн хөдөө аж ахуйн салбарт төрийн оролцоог хязгаарлаж, татаасыг оновчтой болгох, гадаад зээл, тусламжийн хөрөнгийг хувийн хэвшилд дамжуулан зээлэх, Засгийн газрын татаас хэлбэрээр олгох зэрэг үйл ажиллагааг дэмжихгүй.

Хоёр. Зээл, тусламжийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжиж дуусах төслүүдийн хувьд санхүүжилтийг бүрэн олгож, төслийн хугацааг сунгахгүй байх, төслийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй байх замаар хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлж, дуусах чиглэлийг баримтална.

Гурав. Хөгжлийн бодлогод туссан тэргүүлэх ач холбогдолтой шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарна. Эдийн засгийн бодит өсөлт, экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй төслүүд, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх төслүүд, хэрэгжилт хангалтгүйгээс хугацаагаа удаа дараа сунгаж байгаа төслүүд болон шаардлагагүй зөвлөх үйлчилгээг зогсоох, хэрэгжүүлэхгүй байх чиглэл баримтална.

6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, БАРИМТЛАХ СТРАТЕГИ

6.1. Засгийн газрын өр


6.1.1. Улсын нийт гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 34.6 тэрбум ам.доллартой тэнцэж байгаагаас 23.1 тэрбум ам.долларыг аж ахуй нэгжүүдийн гадаад өр, 7.9 тэрбум ам.долларыг Засгийн газрын гадаад өр, 1.8 тэрбум ам.долларыг Төв банкны өр, үлдсэн 1.7 тэрбум ам.долларыг арилжааны банкнуудын өр тус тус эзэлж байна.

Улсын нийт гадаад өрийг зээлдүүлэгч тус бүрээр харуулбал Олон зээлдүүлэгч оролцсон зээллэгийн үлдэгдэл 12.1 тэрбум ам.доллар, Нидерланд улсын 12.0 тэрбум ам.доллар, БНХАУ-ын 3.3 тэрбум ам.доллар, Япон улсын 1.2 тэрбум ам.доллар, Сингапур улсын 1.3 тэрбум ам.доллар, бусад улсын 3.7 тэрбум ам.доллартой тэнцэж байна.

Зураг 6.1. Улсын нийт гадаад өрийн статистик 2018-2023 (тэрбум доллар)

Зураг 6.2. Улсын нийт гадаад өр, зээлдүүлэгчээр /2023.12.31*/



Эх сурвалж: Монголбанк
Тэмдэглэл: *2023 оны урьдчилсан гүйцэтгэл

6.1.2. Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн байдлаар, нэрлэсэн дүнгээр 32.0 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 52.4 хувийн гүйцэтгэлтэй байсан бол 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 30.8 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 38.6 хувьтай тэнцэж нэрлэсэн

үлдэгдлээр 1.2 их наяд төгрөгөөр, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 13.8 хувиар буураад байна.

Хүснэгт 6.1. Засгийн газрын өрийн үлдэгдэл (тэрбум төгрөг)

Өрийн хэрэгсэл	2022	2023*
I. Засгийн газрын дотоод өр	1,035.5	234.1
1.1 Үнэт цаас	1,035.5	234.1
II. Засгийн газрын гадаад өр	29,641.6	30,273.4
2.1 Үнэт цаас	9,359.8	9,371.7
2.2 Зээл	20,281.8	20,901.6
III. Засгийн газрын бусад өр	1,287.7	266.0
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	811.8	29.5
3.2 "Барих-шилжүүлэх" төрлийн концесс	463.5	236.5
3.3 Орон нутгийн зээллэг	12.3	0.0
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	31,964.8	30,773.5
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	70.0%	70.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	52.4%	38.6%

Тэмдэглэл: 2023* оны урьдчилсан гүйцэтгэлээр


Засгийн газрын өрийн буурсан голлох шалтгаан нь МУХБ-ны Япон Улсын санхүүгийн зах зээлд Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргасан "Самурай" бонд банкны өөрийн эх үүсвэрээс бүрэн төлөгдсөн бөгөөд Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсантай холбоотой байна.

6.1.3. Засгийн газрын гадаад зээл

Монгол Улсын Засгийн газрын зүгээс 1991 оноос 2023 оны хооронд нийт 8,706.3 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг 22 зээлдүүлэгчээс 340 төсөл хөтөлбөрт зарцуулсан байдаг. Үүнээс 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нийтдээ 2,163.9 сая ам.долларыг эргэн төлж 6,128.3 сая ам.доллартой тэнцэх үлдэгдэлтэй байна.

1991 оноос хойш авч ашигласан гадаад зээлийн хөрөнгийг төслийн зээлийн хүрээнд нийт 6,203.0 сая ам.доллар, хөтөлбөрийн зээлийн хүрээнд 2,559.4 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг авч ашигласан бөгөөд гадаад төслийн зээлийн ашиглалтын 39.5 хувийг барилгын ажил, 26.2 хувийг тоног төхөөрөмж, 14.4 хувийг үйл ажиллагааны зардал, 12.7 хувийг зөвлөх үйлчилгээний зардалд, 5.1 хувийг магадалшгүй зардалд, үлдсэн 2.1 хувийг санхүүгийн шимтгэлд зарцуулсан байна.

Зураг 6.3. Гадаад зээлийн ашиглалтыг салбар болон зориулалтаар, (2023.12.31-УГ)



Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалтын 46.6 хувийг дэд бүтцэд, 29.2 хувийг эргэлтийн хөрөнгөд, үлдсэн 24.1 хувийг нийгмийн чанартай төсөл хөтөлбөрүүдэд зарцуулжээ. Дэд бүтцийн салбарын 86.8 хувийг зам, тээврийн салбар, үлдсэн 13.2 хувийг уул уурхай, эрчим хүчний салбарууд тус тус эзэлж байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл нийт 20.4 их наяд төгрөг буюу Засгийн газрын өрийн 67.9 хувийг эзэлж байгаа хамгийн том өрийн хэрэгсэл боловч үүнээс гадна ашиглагдаагүй үлдэгдэл болон хэлэлцээрт байгаа төслийн зээлийн хэмжээ 20.5 их наяд төгрөгтэй тэнцэж байна.

Энэхүү ашиглагдаагүй үлдэгдэлд жил бүр хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөр төлдөг бөгөөд гэрээ байгуулсан төслүүдэд нийт 29 тэрбум төгрөгийг төлөхөөр байна. Түүнчлэн, хэлэлцээрт байгаа төслүүдийг авч ашигласнаар улсын төсвийн зарлагад эзлэх гадаад зээлийн ашиглалтын хэмжээний хязгаартай байдлаас шалтгаалж төслийн хэрэгжилт удаашрах эрсдэлт өндөр байна.

6.1.4. Засгийн газрын гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 9,371.7 тэрбум төгрөг буюу 2,747.8 сая ам.доллартой тэнцэж байна.

Хүснэгт 6.2. Гадаад үнэт цаас, 2023.12.31-УГ (тэрбум төгрөг)

№	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Үлдэгдэл
1	Хуралдай	8.750%	7 жил	579.0
2	Номад	5.125%	5.5 жил	1,971.4
3	Сенчири-2027	3.500%	6 жил	1,705.4
4	Сенчири-2028	8.650%	5 жил	2,216.9
5	Сенчири-2029	7.875%	5.5 жил	1,193.7
6	Сенчири-2031	4.450%	10 жил	1,705.4
НИЙТ				9,371.7

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газар 2023 онд нийт 2 удаагийн өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн 2023-2024 онд хүлээгдэж байсан "Гэрэгэ" бондын 517.2 сая


ам.доллар, “Хуралдай” бондын 600 сая ам.долларын төлбөрийг төлж барагдуулсан. Тухайлбал, 01 дүгээр сард 650 сая ам.доллартой тэнцэх “Сенчири-2” өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд “Гэрэгэ” бондын 435.2 сая ам.доллар, “Хуралдай” бондын 207.5 сая ам.долларыг, 12 дугаар сард 350 сая ам.доллартой тэнцэх “Сенчири-3” өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд “Хуралдай” бондын 340 сая ам.долларын төлбөрийг тус тус шийдвэрлэсэн.

Түүнчлэн, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хүрээнд төсөв, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүй хэмжээгээр гадаад үнэт цаасны төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулж байна. Тухайлбал, 2023 оны 05 дугаар сард “Гэрэгэ” бондын 82 сая ам.доллартой тэнцэх хэсгийг, 2024 оны 03 дугаар сард “Хуралдай” бондын 53 сая ам.доллартой тэнцэх хэсгийг тус тус төлж, гадаад үнэт цаасны үлдэгдлийг бууруулсан болно.

Засгийн газар нь дунд хугацаанд онд өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасны дагуу гадаад үнэт цаасны өрийн зохицуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд олон улсын зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын байр сууриас шалтгаалан шинээр хийх өрийн зохицуулалтын арга хэмжээний хугацаа, зардлын түвшин тодорхойлогдоно.

Олон улсын зах зээл гаргасан манай улсын гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээл дээрх өгөөжийг доорх графикт харуулав.

Зураг 6.4. Гадаад үнэт цаас олон улсын зах зээл дээрх өгөөж 2023.01.01-2023.12.31



Дээрх өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2026 онд хүртэлх гадаад төлбөрийн дарамтыг бүрэн шийдвэрлэж байгаа бөгөөд 2026 онд Номад бондын 578 сая ам.доллар, 2027 онд “Сенчири” бондын 500 сая ам.долларын төлбөр хүлээгдэж байна. Тус төлбөрүүдийг Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн зорилтыг үргэлжлүүлж өрийн зохицуулалт

хийх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд гадаад валютын албан нөөц, төлбөрийн тэнцэлтэй уялдуулан төсвийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулах хэмжээг ихэсгэх төлөвлөгөөтэй байна.

6.1.5. Засгийн газрын дотоод өр

Засгийн газрын дотоод үнэт цаас: Сангийн яамны зүгээс Засгийн газрын үнэт цаасыг 2012 оны 12 дугаар сараас эхлэн Монголбанкаар дамжуулан, 2014 оны 11 дүгээр сараас эхлэн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан тус тус нээлттэй хэлбэрээр арилжаалж эхэлсэн.

Засгийн газар 2012-2017 онуудын хооронд 15.9 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг арилжаалсан бөгөөд үүний 70 хувь буюу 11.1 их наяд төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг Монголбанкаар, 10 хувь буюу 1.6 их наяд төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр, үлдсэн 20 хувь буюу 3.2 их наяд төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг хаалттай хэлбэрээр арилжаалсан байна. Түүнчлэн 2013 онд арилжаалсан үнэт цаасны дундаж хүү 9.6 хувьтай тэнцэж байсан бол үнэт цаас гаргалтын хэмжээ, Төв банкны бодлогын хүү зэргээс хамаарч 2016 оны 16.9 хувь, 2017 онд 13.3 хувьд хүрч өсөж байжээ.

Зураг 6.5. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааны хэлбэр (2012-2017)



Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 234.1 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Сангийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 145 дугаар тушаалын дагуу Засгийн газрын өрийн оновчтой багцын бүтцийг бий болгох, Засгийн газрын

санхүүжилтийн хэрэгцээг бага зардлаар, боломжит эрсдэлийн түвшинд хангах зорилгоор 300.0 тэрбум төгрөгтэй тэнцэх Засгийн газрын дотоод үнэт цаасыг 2022 оны 7 дугаар сард “Хадгаламжийн даатгалын корпорац сан”-д, 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 235 тоот тушаалын дагуу “Монгол Улсын Хөгжлийн банк”-нд 383.9 тэрбум төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг арилжаалсан.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хүрээнд дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих, арилжааг тогтмолжуулах, жишиг хүүг тогтоох зорилт тавьсны дагуу 2023 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр Засгийн газрын үнэт цаас гаргах системийг боловсруулсан бөгөөд 2023 онд төсвийн гүйцэтгэл ашигтай гарсантай холбоотойгоор үнэт цаас гаргах шаардлага үүсээгүй байна.

Барих-шилжүүлэх төрлийн концесс: Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 10 концессын гэрээний үлдэгдэл 2022 онд 463.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бол орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 3 концессын гэрээний хүрээнд 0.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Энэхүү үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 236.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Өрийн удирдлагын хуульд мөн өөрчлөлт орж Засгийн газрын өрд концессын үлдэгдлийг оруулахаа больсон тул 2024 оноос эхлэн барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдлийг Засгийн газрын өрийн үлдэгдэлд оруулж тооцохоо больсон болно.

6.2. Засгийн газрын болзошгүй өр төлбөр

“Засгийн газрын өрийн баталгаа” нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд улсын төсөвт учирч болзошгүй өр төлбөрт хамаарна. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэгийн төлбөрийг “Эрдэнэс Монгол” ХХК нь эргэн төлөлтийн хуваарийн дагуу хэвийн гүйцэтгэж байна.

“Эрдэнэс монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын баталгаа 2031 онд бүрэн төлөгдөх хуваарьтай байна.

Азийн хөгжлийн банкнаас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээл “Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 35.0 сая ам.долларын ЛИБОР (6 сар) +0.6 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлийг Азийн хөгжлийн банкнаас авсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаа гаргасан. Зээлийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 8.6 сая ам.доллар байгаа бөгөөд 2031 онд зээл төлөгдөж дуусна.

Түүнчлэн, Засгийн газар болон Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс хамтран өрийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж өөрийн эх үүсвэрээс хугацаа тулаад байсан “Евробонд” болон Засгийн газрын өрийн баталгаатай “Самурай” бондуудыг амжилттай төлж барагдуулснаар Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан бөгөөд 2022 онд 812 тэрбум төгрөгийн

үлдэгдэлтэй байсан Засгийн газрын өрийн баталгааны хэмжээ 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 29.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Улсын Их Хурлын 2023 оны “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” 90 дүгээр тогтоолыг баталсан. Үүний дагуу Засгийн газраас 2024 онд МУХБ-ны дамжуулан зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Чойбалсан ДЦС-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-д өрийн баталгаа гаргах төлөвлөгөөтэй байна.

6.3. Засгийн газрын өрийн тусгай шаардлага

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2024 онд 60 хувиас хэтрэхгүй байхаар заасан байдаг. Засгийн газрын өрийн харьцаа үзүүлэлт дунд хугацаанд хийсэн суурь төсөөллөөр 2024 онд 39.6 хувь, 2025 онд 37.3 хувь, 2026 онд 37.8 хувь, 2027 онд 38.2 хувьтай тус тус тэнцэж байгаа бөгөөд энэ нь нэрлэсэн дүнгээр харгалзан 45.1 хувь, 42.0 хувь, 42.3 хувь, 42.4 хувьтай тус тус тэнцэж төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлагад бүрэн нийцэхээр байна.

Иймд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2025 онд 50 хувь, 2026 онд 45 хувь, 2027 онд 40.0 хувь байхаар тооцлоо.

6.4. Засгийн газрын 2023-2025 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичиг

Засгийн газрын зүгээс “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг боловсруулж үндсэн 6 зорилтыг дэвшүүлсэн.

Зорилт 1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна.

1.1 Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглахаас татгалзах;

Засгийн газар хөгжлийн түншүүдтэй хөгжлийн хамтын ажиллагааны дунд хугацааны стратегийг тохиролцон Засгийн газрын шугамаар гадаад улс, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас зээл авахдаа зээлийн ерөнхий хэлэлцээр байгуулагдсан, тусгайлсан зээлийн хэлэлцээрээр эх үүсвэр баталгаажсан, эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээ байх шаардлагыг тавьж, үргэлжилж буй төслүүдийн хувьд тухайн жилд дуусгавар болох төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тусгах, тэргүүлэх ач холбогдолтой, амжилттай хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг дэмжих зарчмыг баримтлан ажиллаж байна.

Энэ хүрээнд Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг сайжруулах, төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулах арга хэмжээний хүрээнд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банктai 6 сарын турш хэлцэл хийж 2023 оны 8 дугаар сарын 17-ны өдөр “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн 1.0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд дэд гэрээнүүдэд гарын үсэг зурсан.

Дэд зээлийн гэрээнүүдийг байгуулснаар EPC-02, EPC-03 багц ажлын зээлийн эргэн төлөлт болох 789 сая ам.долларын үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацааг дахин 7 жилээр хойшлуулж, 2023 оноос эхлэн зээлийн үндсэн төлбөрт 64.5 сая ам.доллар төлж эхлэх байсныг 13.1 сая ам.доллар болгон бууруулж, төсвийн дарамтыг багасгасан. Мөн 2018 оноос хойш хийгдэхгүй гацаанд ороод байсан EPC-02, EPC-03 багц ажлын санхүүжилт авах боломжийг бүрдүүлж төслийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлээд байна.

Түүнчлэн, Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан боловч бэлтгэл ажил хангагдаагүй, импортыг нэмэгдүүлж экспортыг дэмжихгүй төслүүдээс татгалзах зарчмыг баримтлан ажиллаж байна. Тухайлбал, Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх-2 төсөл”, “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл”, Бүгд Найрамдах Польш улсын “Хүнсний ногооны үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл” болон Бүгд Найрамдах Беларусь улсын “Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх” зэрэг төслүүдээс татгалзаад байна.

Зорилт 2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

2.1, 2.2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх, өрийн зохицуулалтын арга хэмжээ, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Дахин санхүүжилтийн арга хэмжээний хүрээнд Засгийн газар 2023 онд нийт 2 удаагийн өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн 2023-2024 онд хүлээгдэж байсан “Гэрэгэ” бондын 517.2 сая ам.доллар, “Хуралдай” бондын 600 сая ам.долларын төлбөрийг төлж барагдуулсан. Тухайлбал, 01 дүгээр сард 650 сая ам.доллартой тэнцэх “Сенчири-2” өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд “Гэрэгэ” бондын 435.2 сая ам.доллар, “Хуралдай” бондын 207.5 сая ам.долларыг, 12 дугаар сард 350 сая ам.доллартой тэнцэх “Сенчири-3” өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд “Хуралдай” бондын 340 сая ам.долларын төлбөрийг тус тус шийдвэрлэсэн.

Гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх арга хэмжээний хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр эргэн төлөгдөх хуваарьтай Чингис бондын үлдэгдэл 136.8 сая ам.долларыг 2022

оны 12 дугаар сарын 5-ны өдөр , Гэрэгэ бондын үлдэгдэл төлбөр болох 82.0 сая ам.долларыг 2023 оны 04 дүгээр сарын 28 -ны өдөр гадаад валютын албан нөөцөд дарамт учруулахгүйгээр тус тус улсын төсвөөс төлж дуусгах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн.

Дээрх өрийн дахин санхүүжилтийн арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2026 онд хүртэлх гадаад төлбөрийн дарамтыг бүрэн шийдвэрлэж байгаа бөгөөд 2026 онд Номад бондын 578 сая ам.доллар, 2027 онд “Сенчири” бондын 500 сая ам.долларын төлбөр хүлээгдэж байна.

2.3. Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах үүднээс зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол ханган хамтарч ажиллах;

Засгийн газрын зүгээс 2023 оны 06 дугаар сард олон улсын хөрөнгө оруулагчидтай роудшоу уулзалт (non deal roadshow) зохион байгуулсан. Энэхүү уулзалтын гол зорилго нь Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, Монгол Улсын Хөгжлийн банкны үнэт цаасны эргэн төлөлт болон Хуралдай бондын эргэн төлөлтийн талаар мэдээллийг хүргэсэн бөгөөд хөрөнгө оруулагчдын саналыг сонсох байсан.

Түүнчлэн, 2023 оны 05 дугаар сард олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлагийн төлөөлөлтэй, 07 дугаар сард Эс энд Пи агентлагийн төлөөлөлтэй тус тус уулзалтыг зохион байгуулж, зээлжих зэрэглэл тогтоолгосон бөгөөд Монгол Улсын 2023 оны зээлжих зэрэглэлийг В тогтвортой түвшинд хэвээр хадгалаад байна. Мөн цаашид зээлжих зэрэглэлээ нэмэгдүүлэхэд дараах нөхцөлийг тавьсан болохыг мэдэгдсэн. Үүнд:

- ГВАН-ийг их хэмжээгээр нэмэгдүүлж, Засгийн газрын гадаад өрийн удирдлагын стратегийг хэрэгжүүлж, гадаад санхүүжилтийн хэрэгцээг бууруулж тогтвортой байдлыг хадгалах;
- Макро эдийн засгийн зөв, зохистой бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, түүхий эдийн үнийн болон олон улсын эдийн засгийн савлагаанд хэт мэдрэг байдлыг бууруулж, гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэхэд таатай бизнесийн орчныг бүрдүүлэх;
- Засгийн газрын өрийн ДНБ-тэй харьцах харьцааг тогтмол бууруулах;
- Монгол Улсын эдийн засаг таамаглаж байгаагаас илүү буюу ижил орлоготой улс орнуудтай харьцуулахад сайжрах;
- Эдийн засгийн өсөлт хүлээлтээс давж өссөн тохиолдолд энэ нь төсөв, өр, гадаад зах зээлийн үзүүлэлтийг хурдан сайжруулах;
- Монгол Улсын тогтолцооны шинэчлэл, сайжруулалт хийх, ялангуяа бодлого боловсруулахдаа бодит ахиц дэвшил гаргах зэрэг болно.

Зорилт 3. Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

3.1.Дэлхий нийтэд тулгараад байгаа нь инфляцын өсөлтөөс шалтгаалан гадаад зах зээлд бий болоод байгаа хүүгийн өсөлтөөс хамааран урт, дунд хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн хөвөгч хүү өсөх тохиолдолд тогтмол хүүтэй зээл авах нөхцөлийг зээлдүүлэгч талд тавьж ажиллах;

Засгийн газрын гадаад зээлийг авахдаа зээлийн хөнгөлөлтийн түвшнийг харгалзан үзэж Засгийн газраас гадаад зээл шинээр авах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ зээлдэгч байгууллагатай зээлийн хэлэлцээрт 2023 оны байдлаар 5 хувьтай тэнцэж байгаа хөвөгч хүүг багасгах бодлогыг баримталж ажиллаж байна. Тухайлбал, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаар батлагдсан “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 560.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийн 420.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийг тогтмол хүүтэй, үлдсэн 140 сая ам.долларыг хөвөгч хүүтэй нөхцөлтэйгөөр авч ашиглах болгож зээлийн нөхцөлийг сайжруулаад байна.

3.2.Орон нутгийн засаг захиргааны өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх, Засгийн газрын өрийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх талаар хамтран ажиллах;

Өрийн удирдлагын тухай хуулийн 281 дүгээр зүйлийн 281.7 дахь хэсэгт “аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Засгийн газарт баталж мөрдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 199 дүгээр “Журам батлах тухай” тогтоолын хавсралтаар “Нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ыг баталж Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дотоодын зах зээлд үнэт цаас гаргах эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн болно.

Зорилт 4. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.

4.1.Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан арилжааны систем нэвтрүүлэх;

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл ашигтай, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл харьцангуй сайн байгаа зэргээс шалтгаалан 2023 онд Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалах шаардлага үүсээгүй болно. Засгийн газрын зүгээс төсвийн алдагдал болон төрийн сангийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор 2024 онд Засгийн газрын дотоод үнэт цаасыг зохистой хэмжээгээр олон нийтэд нээлттэй, нэгдсэн зах зээл дээр арилжаалах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Зорилт 5. Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлана.

5.1.Эдийн засаг болон нийгмийн үр өгөөж өндөртэй төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан, "Шинэ сэргэлтийн бодлого"-д нийцсэн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх;

“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан стратегийн чухал ач холбогдол бүхий төсөл болох “Чойбалсан Дулааны Цахилгаан Станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлж, өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Улсын Их Хурлын 2023 оны 90 дүгээр тогтоолоор тус төслийн хүрээнд 2024 онд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар шийдвэрлэсэн. Уг төсөл амжилттай хэрэгжсэнээр Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум, багийн 25,139 айл өрх, 3,133 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 13 ордын олборлох үйлдвэрүүд тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангагдаж, БНХАУ-аас импортоор авдаг эрчим хүчний хэмжээг жилд 438 сая кВт.цагаар бууруулах ач холбогдолтой юм.

5.2. Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслүүдийн эргэн төлөлт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах;

Засгийн газрын өрийн баталгаа гаргасан байгууллагууд болох “Эрдэнэс Монгол” болон Монгол Улсын Хөгжлийн банкны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтэд эрсдэлийн үнэлгээг хийсэн бөгөөд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Төрийн аудитын үйл ажиллагаагаар 2023 оны 06 сард хянуулж ажилласан.

5.3.Төсвөөс шууд төлөгдөх нөхцөлтэй Барих-Шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулахгүй, өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй байх;

Засгийн газраас шинээр Барих-Шилжүүлэх нөхцөлтэй концессын төрлийн гэрээ болон өрийн бичиг нэмж байгуулаагүй бөгөөд цаашид стратегийн баримт бичигт заасан арга хэмжээг баримталж ажиллана. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Өрийн удирдлагын хуулийн дээрх заалтад өөрчлөлт орж Засгийн газрын өрд тооцож бүртгэх шаардлагагүй болсон тул 2024 оноос эхлэн барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдлийг Засгийн газрын өрийн үлдэгдэлд оруулж тайлагнахгүй байхаар зохицуулагдсан.

Зорилт 6. Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна.

6.1.Улирал бүр Засгийн газрын өрийн товхимлыг олон нийтэд ил тод мэдээлэх;

Засгийн газрын өрийн статистикийн товхимлыг улирал бүр бэлтгэн Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд олон нийтэд ил тод байдлаар байршуулж байна.


6.2.Улсын секторын өрийн мэдээллийг олон улсын байгууллагаас тогтоосон нэгдсэн стандартын дагуу бэлтгэж, мэдээлэх;

Улсын секторын өрийн мэдээллийг Төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан 98 хуулийн этгээдүүдээс цуглуулж нэгтгэн хагас жил бүр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Сангийн яамны цахим хуудсанд олон улсын байгууллагаас тогтоосон стандартын дагуу нийтэд ил тод байдлаар тайлагнаж байна. Түүнчлэн мэдээллийг нэгтгэсэн санг сайжруулах ажлыг зохион байгуулж E-balance санхүүгийн тайлангийн системд тогтсон загварыг үүсгэн байгууллагуудаас мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг боловсронгуй болгосон.

Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс

Монгол Улсын Засгийн газрын өр, ДНБ-ний харьцаа 2017-2019 онуудад буурсан нь ДНБ-ний өсөлт болон бодит хүүгийн түвшнээс хамаарсан байна. Цаашид ч бодит ДНБ-ний өсөлтийг дэмжиж, төсвийн үндсэн тэнцлийг бууруулах нь өрийн тогтвортой байдлыг хангах суурь үндэс болохоор байна. 2020 оны хувьд цар тахлаас шалтгаалж төсвийн тэнцэл алдагдалтай, ханш суларсан бодит эдийн засгийн өсөлт сөрөг гарсан тул өрийн хэмжээ нэмэгдсэн байна. 2022 онд валютын ханш огцом суларсан ч эдийн засгийн бодит өсөлт, инфляцын түвшин өндөр байгаагаас шалтгаалж ДНБ-ний хэмжээ өссөн нь ДНБ-д эзлэх өрийн хэмжээг буурахад нөлөө үзүүлсэн байна. Засгийн газрын өр болон ДНБ-ний харьцаа эдийн засгийн өсөлтөөс шалтгаалж буурах төлөвтэй байна.

Зураг 6.6. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс



Эх сурвалж: Сангийн яамны тооцоолол

2024 оноос эхлэн Засгийн газрын өрийн хэмжээ өсөхөөр байгаа нь Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийн өөрчлөлтөөс шалтгаалж байгаа ч энэ нь 2024 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын өрийн баталгаа гаргах боломжтой төслийг оруулснаар тооцоолсон. Гэсэн хэдий ч тус баталгааг гаргаагүй үед тухайн хэмжээгээр Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ буурахаар байгаа юм.

Ингэснээр 2023-2027 оны хооронд Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 1.5 хувиар буурахаар байгаагаас бодит ДНБ-ний өсөлтөөс шалтгаалж 9.4 хувиар, бодит хүүгийн түвшнээс шалтгаалж 4.5 хувиар тус тус буурахаар байгаа бол, төсвийн тэнцлээс шалтгаалж 2.9 хувиар, ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж 1.9 хувиар, Засгийн газрын өрийн баталгаанаас шалтгаалж 7.6 хувиар тус тус буурах төсөөлөлтэй байна.

Өрийн эрсдэлийн шинжилгээ

Богино хугацаа

Монгол Улсын Засгийн газрын өрийг Стрессийн ложит загвараар тооцсон бөгөөд тус загварт өгөгдлийг оруулж тооцоход 2022 онд стресс болох магадлал 44 хувьтай тэнцүү буюу эрсдэл өндөр байсан бол 2023 онд стресс тохиох магадлал 13 хувь буюу хэвийн эрсдэлтэй гэж үнэлэгдэж байна.

Хүснэгт 6.3. Богино хугацааны загварын өөрчлөлтийн шалтгаан

Огноо	2020	2021	2022	2023
Стресс таамаглах	2021-22	2022-23	2023-24	2024-25
Ложит стрессийн магадлал	0.653	0.144	0.437	0.130
Ложит стрессийн агадлал				
Магадлалын өөрчлөлт	0.476	-0.509	0.293	-0.307
Үүнээс:				
Институцын чанар	0.032	0.028	0.000	0.000
Стрессийн түүх	0.000	-0.012	-0.009	-0.008
Мөчлөг	-0.052	0.048	0.050	0.009
Өрийн дарамт	0.360	-0.357	0.110	-0.212
Олон улсын нөхцөл байдал	0.175	-0.264	0.148	-0.101

Тус стресс тохиох магадлал буурсан гол шалтгаан нь 2023 онд Засгийн газрын өрийн дарамт буурсан, олон улсын нөхцөл байдал сайжирсантай холбоотой байна.

Дунд хугацаа

Харин Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээний эрсдэлийг тооцохдоо дараагийн 5 жилд санхүүжилтийн хэрэгцээний дундаж түвшин, арилжааны банкуудын ЗГ-аас авах авлагын хэмжээ болон стрессийн үед ЗГ-аас авах авлагын хэмжээ хэрхэн өсөх төсөөллийг тооцдог бөгөөд шинжилгээгээр бага эрсдэлтэй гарсан байна. Энэ нь 2026 он хүртэл томоохон өр төлбөрийг төлж барагдуулснаар санхүүжилтийн хэрэгцээний дундаж түвшнийг бууруулсантай холбоотой байна.

Хүснэгт 6.4. Дунд хугацааны үр дүн

Загвар	Үзүүлэлт	Хэмжээ	Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн сэрэмжлүүлэг
Өрийн Фэнчарт	Фэнчартын өргөн	113.6	1.6	...
	Өр тогтворгүй байх магадлал	28.2	0.2	...
	Өрийн түвшин х Институцын индекс	34.5	0.8	...
	Өрийн Фэнчартын индекс	...	2.6	Өндөр
Санхүүжилтийн хэрэгцээ	Санхүүжилтийн хэрэгцээний дундаж хэмжээ	8.8	3.0	...
	Нийт хөрөнгөд эзлэх Банкны ЗГ-аас авах авлага	2.7	0.9	...
	Стрессийн үед Банкны ЗГ-аас авах авлагын өөрчлөлт	3.9	1.3	...
	Санхүүжилтийн хэрэгцээний индекс	...	5.2	Бага

Харин Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээний эрсдэлийг тооцохдоо дараагийн 5 жилд санхүүжилтийн хэрэгцээний дундаж түвшин, арилжааны банкуудын ЗГ-аас авах авлагын хэмжээ болон стрессийн үед ЗГ-аас авах авлагын хэмжээ хэрхэн өсөх төсөөллийг тооцдог бөгөөд шинжилгээгээр бага эрсдэлтэй гарсан байна. Энэ нь 2026 он хүртэл томоохон өр төлбөрийг төлж барагдуулснаар санхүүжилтийн хэрэгцээний дундаж түвшнийг бууруулсантай холбоотой байна.

Ингэснээр доор харуулж буй хүснэгтээр тус 2 эрсдэлийн үзүүлэлтийг индексжүүлж авч үзэхэд дунд хугацаанд Засгийн газрын өрийн эрсдэл хэвийн түвшинтэй байна.

Хүснэгт 6.5. Засгийн газрын өрийн эрсдэлийн түвшин

Хугацаа	Механик дохио
Богино хугацаа 1/	Хэвийн
Дунд хугацаа	Хэвийн
Фэнчарт	Өндөр
Санхүүжилтийн хэрэгцээ	Бага

Ингэснээр Засгийн газрын өрийн эрсдэлийн түвшин богино хугацаанд хэвийн, дунд хугацаанд хэвийн түвшинтэй гарч байна. Харин 2022 онд ОУВС-аас Улсын секторын өрийн хүрээнд хийсэн тус шинжилгээгээр өндөр эрсдэлтэй гэж гарч байсан. Энэ нь МУХБ-ны бондууд төлөгдөх, Монголбанкны своп төлөгдөх, Засгийн газраас Хуралдай бонд, Гэрэгэ бондыг төлөхөөр хүлээж байсантай холбоотой.

Дээрх өрийн эргэн төлөлтүүдийг хуваарийн дагуу 2023 онд бүрэн төлж барагдуулаад байгаа бөгөөд Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 60.5 хувьтай тэнцэж байснаас 44.8 хувь болж 15.7 хувиар буурсан, эдийн засгийн өсөлт 7 хувьтай тэнцэж, ГВАН-ийн хэмжээ 3.4 тэрбум ам.доллараас 4.9 тэрбум ам.доллар болж өссөн, төлбөрийн тэнцэл 1.5 тэрбум ам.долларын ашигтай, төсвийн тэнцэл 763 тэрбум төгрөгийн ашигтай гарсан зэрэг эдийн засгийн эерэг үзүүлэлтүүдтэй холбоотойгоор эрсдэлийн түвшин буурсан байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2025 он	2026 он	2027 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	6.5	6.5
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.0	4.0	3.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	29,400.1	31,951.2	34,460.3
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	30.9	30.5	29.5
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	31,300.4	33,521.8	35,628.1
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.9	32.0	30.5
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	3,939.9	2,221.4	2,106.3
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	4.1	2.1	1.8
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,900.3	-1,570.6	-1,167.8
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-1.5	-1.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	7,273.3	7,564.2	7,866.8
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	7.7	7.2	6.7
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	47,507.1	47,117.6	46,708.6
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	50.0	45.0	40.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,850.4	2,931.8	3,269.6
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.0	2.8	2.8

Гарын үсэг

**ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙГ
ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛЛӨӨС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ**

№	Санал ирүүлсэн байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Тайлбар
1	Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн	1	Зарлага/ДНБ бууруулах.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
		2	Инфляц хэт өөдрөг байна.	Инфляц өндөр байх нь өрхийн худалдан авах чадвар, эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг тул инфляцыг зохистой түвшинд хүртэл бууруулах нь зүйтэй байна. Иймд дунд хугацаанд хөдөө аж ахуйн салбарт цогц шинэчлэл хийж хүнсний нийлүүлэлтийн сүлжээг нэмэгдүүлэх, валютын зах зээлийг тогтвортой хэвээр хадгалах, төсвийн алдагдлыг хязгаарлах бодлого баримтлан инфляцыг зохистой түвшин хүртэл бууруулах тухай Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгасан.
		3	Төсвийн тооцоо хэт өөдрөг байна.	Дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг 6 хувиас дээш тогтвортой хадгалж, гадаад валютын нөөцийг 2 дахин нэмэгдүүлж 10 тэрбум ам.долларт хүргэх бодлого баримтлах тухай Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгасан.
2	Санхүү Эдийн Засгийн Их	4	Бодлогын хөдөлгөгч хүчинд хөнгөн эдийн засгийн тус нэмрийг	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл,

4	Сургууль		талаар заах.	2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
		5	ЖДҮ-г түлхүү дэмжсэн төсвийн бодлого баримталж, хөрөнгө оруулалтын орон зай гаргах.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
		6	Хөдөө аж ахуй болон боловсруулах салбарыг уялдуулан төрөлжүүлэх бодлого дутуу байна. Боловсруулах салбарт хөрөнгө оруулалт татах.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
3	“Мандах” их сургууль	7	Тэтгэвэр, цалингийн нэмэгдэл инфляцад хэрхэн нөлөөлөх нөлөөллийг судлах	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
		8	Төсвийн бодлого мөнгөний зорилготой хэр зохицсон бэ?	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
		9	Төсвийн орлого, уул уурхайтай хэт хамааралтай байна. Эдийн засгийг төрөлжүүлэх хэрэгтэй байна. Төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд далд эдийн засгийг багасгах хэрэгтэй байна.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
4	Дэлхийн банк	10	Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулахад баримтлах бодлогыг тусгах.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд зудын эрсдэлийн талаар тооцоолж, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх бодлогод тусгасан. Цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
		11	Тодотгол хийх боломж	Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой

5	Иргэн		хязгаарлагдаж байгаа тул сайн муу 2 хувилбараар ТХМ-г танилцуулдаг байх.	байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын хүрээнд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулсан.
		12	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өрийн хязгаарыг тогтоохдоо нийт өр/ДНБ гэж тогтоох боломжтой юу?	Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын хүрээнд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулсан.
		13	Төсвийн хүрээний мэдэгдлийн 3 жилээр баталж гаргадаг улсуудын талаар судалгаа хийх.	Саналыг хүлээн авч, холбогдох судалгааг хийж байна.
		14	2,3 жилээр төлөвлөгөөний үр дүнг тооцож гаргасан уу?	Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын хүрээнд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулсан.
		15	Салбар дундын хэрэгжилтийг хангах.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд саналыг тусгасан. Цаашид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад энэ асуудлыг анхаарч ажиллана.
		16	Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахдаа салбарын яамдаас санал авах.	Төсвийн тухай хуулийн 8.1.1-т Эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулна гэж заасан.
		17	Төрийн хяналт хийдэг байгууллагуудын хуулийн хэрэгжилтэд хандах хандлагыг хэрхэн өөрчлөх вэ?	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд хамааралгүй тул тусгаагүй.

6	Иргэн	18	Төрийн албан хаагчийн цалин, хөлсийг нэмэгдүүлэх	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд инфляцтай уялдуулан нэмэх тухай саналыг тусгасан.
		19	Цалин, тэтгэвэр нэмэх.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд инфляцтай уялдуулан нэмэх тухай саналыг тусгасан.

ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ
САНАЛ

2024 оны 3 дугаар
сарын 29-ний өдөр

Овог нэр, байгууллага:

Б. Тувшинтөгс MNC & ERI

Холбоо барих мэдээлэл /утас, цахим хаяг/:

tuвшинтөгс @ eri.mn

Санал:

- Inflation зогшил хэт өөррөл
- Төсвийн тооцоолол хэт өөррөл болох тооцоол үүрэх "Төсв-г илүүдэл" хуули болгох.
- $\frac{3\% \text{ Зарнах}}{ДНБ}$ гээр 4-нээс зогшил таваг

ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ
САНАЛ

2024 оны 3 дугаар
сарын 29-ний өдөр

Овог нэр, байгууллага:

Д.Түвшинжаргал, СЭЗУС.

Холбоо барих мэдээлэл /утас, цахим хаяг/:

tuvshinjargal.0@uk-elm

Санал:

Бүрэлтэй иргэдийн хурал

1. Хурал өдөр, нэг үеэ эхлэх өмнө
хуралд зөвхөн бүрэлтэй,
нэгдсэн, нэгдсэн үеэ эхлэх өмнө
хуралд зөвхөн бүрэлтэй

2. Хурал, нэг үеэ эхлэх өмнө
хуралд зөвхөн бүрэлтэй,
нэгдсэн үеэ эхлэх өмнө

3. Хуралд зөвхөн бүрэлтэй,
нэгдсэн үеэ эхлэх өмнө,
нэгдсэн үеэ эхлэх өмнө,
нэгдсэн үеэ эхлэх өмнө

ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ
САНАЛ

2024 оны 3 дугаар
сарын 29-ний өдөр

Овог нэр, байгууллага:

Мандах ах Сургууль

Холбоо барих мэдээлэл /утас, цахим хаяг/:

99079599

Санал:

1. "Я архуй хийе", Цэвэр
мэргэжлийн нэгж
мэргэжлийн танилцуулга
мөнх мөнгөөрөөс хэр.
2. Тасламт өргөтгөл мөнгөний
догологой хт үргээхд?
3. Тасламт өргөтгөл, хөнгө
уур үүрхэлгээх хт
хөнгөмтэйг өргөтгөл.
Тасламт үргээхт өргөтгөл
хөнгөмтэйг өргөтгөл.
Тасламт өргөтгөл мөнгөний
догологой үргээхт хт
хөнгөмтэйг өргөтгөл.

ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ
САНАЛ

2024 оны 3 дугаар
сарын 29-ний өдөр

Овог нэр, байгууллага:

ДВ. Чиграл.

Холбоо барих мэдээлэл /утас, цахим хаяг/:

ibattmunkh@worldbank.org.

Санал:

- 1) Эдийн засгийн урт хугацааны бодлогын хүрээнд уур амьсгалын өөрчлөлт, туршиг нэвчлэлийн сааруулах талаар ямар бодлого баримтлах вэ?
- 2) Төсвийн дунд хэрээний мэдэгдлийн боловсруулалтад уур амьсгал, сийн муу /эргэлдэний харилцаа /рост 2 бүхэлбэрийн боловсруулалт танилцуулалт байгаа болох уу?
Ямарчлэн төсвийн хэрээний мэдэгдэл өргөсдөг боловч тэр байгаа эсэх үү...
- 3) Төсвийн ояворон байрны тухай оруулж өрийн алдааны боловсрол мэт өр /ДНБ-ийн тухай баримттай үү? ӨҮЧ-р бичиг, нэрлэлт зүйлээр.

ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ
САНАЛ

2024 оны 3 дугаар
сарын 29-ний өдөр

Овог нэр, байгууллага:

Црлм

Холбоо барих мэдээлэл /утас, цахим хаяг/:

Санал:

1. Төсвийн хуртны мэдэгдлийн 3-мийн
бодол дотроо мэдэгдлийн ал (сүл) үе
багдал вэ? 2. 3-мийн төсвийн үр дүн
тооцон гаргасан үү?
3. Санал дунд хуртны мэдэгдлийн хурт
хуртны ал вэ вэ?
4. Саналын мэдэгдлийн санал авах
төсвийн хуртны мэдэгдлийн төсвийн
нь хур үр дүн багдал вэ вэ?
5. Төсвийн мэдэгдлийн багдалууд
хуртны мэдэгдлийн багдалууд

коричневая окраска в.

ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ
САНАЛ

2024 оны 3 дугаар
сарын 29-ний өдөр

Овог нэр, байгууллага:

ЦРЭГ

Холбоо барих мэдээлэл /утас, цахим хаяг/:

УУ

Санал:

Төрийн албан хаагчийн цалин, хөлс
нэмэгдүүлэх.
Мэтгэвэр мөч нэмэх.

АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхтэй холбоотой Эдийн засаг, хөгжлийн яамнаас оролцох ажлын хэсгийн нэрс:

№	Нэр	Албан тушаал	Утас
1	Ч.Хүрэлбаатар	Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	99112317
2	Г.Түвдэндорж	Эдийн засаг, хөгжлийн дэд сайд	99112910
3	И.Батхүү	Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	99113569
4	Л.Энх-Амгалан	Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга	80770972
5	Л.Балчинлуvsан	Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	88040439
6	Б.Анар	Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга	99078437
7	Б.Мөнх-Эрдэнэ	Эдийн засаг, хөгжлийн яамны Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга	88886495
8	Т.Мөнхцэцэг	Эдийн засаг, хөгжлийн яамны Өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга	86864321
9	Б.Мөнгөнсүх	Эдийн засаг, хөгжлийн яамны Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга	99119675
10	Ш.Маргад	Эдийн засаг, хөгжлийн яамны Үйлдвэржилт, дэд бүтцийн хэлтсийн дарга	99117608
11	О.Мөнхтөр	Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга	99996388

---o0o---